

**СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН:  
ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Д.Халиун, Д.Жигваагүнсэл  
Р.Оргилмаа, Ц.Элбэгзаяа*

**АГУУЛГА**

**СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ**

**НЭГ. СУРГУУЛИЙН ХООЛЫГ ЕВРОПЫН ЗАРИМ ОРОНД  
ЗОХИЦУУЛСАН ТУРШЛАГА**

**ХОЁР. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН  
ОРЧИН**

- Япон улс
- БНСУ
- БНХАУ
- ОХУ
- Словени улс

**АШИГЛАСАН МАТЕРИАЛ**



## СУДАЛГААНЫ ХУРААНГҮЙ

**Хамрах хүрээ:** Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтэд дурдсан Япон, БНСУ, БНХАУ, ОХУ болон сургуулийн хоолны асуудлыг бие даасан хуулиар зохицуулсан Словени Улсын цэцэрлэг, сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг зохицуулж буй эрх зүйн орчин, туршлагыг судалсан болно. Түүнчлэн, Европын зарим орнуудад сургууль, цэцэрлэгийн хоолыг хэрхэн зохицуулсан талаарх тоймыг бэлтгэв. Судалгааны сэдвийн хүрээнд сургуулийн хоолны бие даасан зохицуулалт бүхий орнуудын хууль тогтоомжийг хуулийн агуулга, бүтцийн хүрээнд (зохицуулж буй харилцаа, нэр томъёоны тодорхойлолт, сургуулийн хоолны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хяналтын тогтолцоо, хариуцлагын механизм гэх мэт) судалж, судалгааны мэдээллийг Хүснэгт 1-д хураангуйлан үзүүлэв.

**Судалгааны үр дүнгийн тойм:** Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал нь үндэсний аюулгүй байдлын нэг хэсэг болох хүнсний аюулгүй байдалтай салшгүй холбоотой байдаг. Ихэнх орнуудын хувьд цэцэрлэг, сургуулийн сурагчдыг хоолоор хангах асуудал нь боловсрол, хүнсний аюулгүй байдал, нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль тогтоомжууд, холбогдох бодлогын баримт бичгүүд, хоолны эрүүл ахуй, шим тэжээлийн стандартуудын хүрээнд зохицуулагдаж байна. Судалгаанд хамрагдсан орнуудаас Япон, БНСУ, Словени Улс нь сургуулийн хоолны бие даасан хуультай байна.

БНСУ-ын хувьд үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид Сургуулийн өдрийн хоол дэмжих төвөөр дамжуулан хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сургуульд нийлүүлдэг байна. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх компанийг уралдаант шалгаруулалтаар сонгон шалгаруулж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ханганд нийлүүлэх гэрээ байгуулан ажилладаг. БНСУ-ын хувьд сүүлийн жилүүдэд сургуулийн хоолны хордлого, хордлогот халдварын тоо нэмэгдсэн (2017 онд өмнөх онтой харьцуулахад 34 хувь, 2011-2015 оны дундажтай харьцуулахад 52 хувиар тус тус нэмэгдсэн)<sup>256</sup>-тэй холбоотойгоор явуулсан хяналт, шалгалтаар сургууль, бэлтгэн нийлүүлэгчид шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн нийлүүлдэг, сургууль нь хүлээн авч буй хоол, хүнсэнд зохих хяналт, шалгалт явуулах чадавх муу, сургуулийн гол тогоонд тавигдах хяналт сүл мөн бэлтгэн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой зөрчлүүд ихээр илэрсэн байна. Боловсролын яамнаас холбогдох хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгахаар мэдэгдсэн ба эцэг, эхчүүдийг сургуулийн хоолонд тавих хяналтад идэвхтэй оролцохыгuriалсан байна.

Японы хувьд сургуулийн хоолны эрүүл ахуйн асуудалд ихээхэн анхаарал хандуулан ажилладаг ба холбогдох статистик тоо, мэдээнээс үзэхэд<sup>257</sup> сургуулийн хоолны хордлого, хордлогот халдварын тоо сүүлийн жилүүдэд тасралтгүй буурсан үзүүлэлттэй гарсан байна. Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтыг 2011 оноос хойш (цацраг идэвхт бодисын аюул гм.) эрчимжүүлсэн ба бүх сургуулийн гол тогоонд хоол, хүнсний аюулгүй байдлын НАССР<sup>258</sup> тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Бэлтгэн нийлүүлэгчдийг мужийн Сургуулийн хоолны холбоод нарийн шалгуураар сонгон шалгаруулдаг. Засгийн газрын хорооноос (Government Committee) сургуулийн хоолны эрүүл ахуйн хяналт, шалгалтыг сайжруулах асуудлаар нэлээдгүй хүчин чармайлт гарган ажилладаг ба сургуулийн ажилтнуудад эрүүл ахуйн хяналт, шалгалтыг хэрхэн үр дүнтэй явуулах талаар зааж сургаж, удирдамжаар хангадаг байна.

БНСУ болон Японд сургачдын хооллох зөв дадал, зуршил бий болгох, мэдлэг өгөх үүднээс хоол зүй, шим тэжээлийн багш ажиллуулдаг. Эдгээр улсад сургачдыг шим тэжээлтэй хоолоор хангаж, хооллолтын зөв дадал зуршлыг төлөвшүүлэхээс гадна хоолоор дамжуулан хүүхдийг хүмүүжүүлэх, амьдралд бэлтгэх, үндэсний уламжлалт хоолны соёлоо хадгалж, өвлүүлэхэд ихээхэн анхаардаг байна.

1964 онд Японы Боловсролын яамнаас хоол зүйчдийн цалинг хэсэгчлэн санхүүжүүлэх болсноор сургуулийн хоол зүйч бий болсон байна. Үүнээс өмнө сургуулийн

<sup>256</sup> <http://www.koreaherald.com/view.php?ud=20160824000869>

<sup>257</sup> The Japanese School Lunch and Its Contribution to Health, Nutrition today, December 2015

<sup>258</sup> Hazard Analysis and Critical Control Point

хоол зүйч гэх мэргэжил, орон тоо байгаагүй бөгөөд сургуулийн тогооч нь хоолны бэлтгэл, төлөвлөлтийг хариуцан, чөлөөт цагаараа шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа явуулдаг байжээ. 1990 оноос хойш нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтүүдийг (түргэн хоолны үйлчилгээ нэмэгдсэн, эцэг, эхчүүдийн ажлын ачаалал ихэссэн, ажлын цаг уртассан гм.) даган сургуулийн хоол, шим тэжээлийн боловсролд анхаарал хандуулах шаардлага гарч, сургуулийн хоол зүй, шим тэжээлийн багшид тавигдах шаардлага нэмэгдсэн байна. Улмаар 2005 онд Шим, тэжээлийн багш нарыг линцензжуулж, 2007 оноос хоол зүй, шим тэжээлийн боловсролын тогтолцоог нэвтрүүлжээ.

БНХАУ, ОХУ нь сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй бөгөөд зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан хөтөлбөрүүд болон Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (БНХАУ), Боловсролын тухай хууль (ОХУ)-иар тус тус зохицуулж байна. Сургуулийн хоолны тогтолцоо нь сургууль, хот, хотын захиргаа, аймаг/субъект (ОХУ-ын засаг захиргааны нэгж)-ын хүрээнд бие даасан байдалтай явагдаж байна.

ОХУ-ын хувьд сүүлийн үед сургуулийн хоолны хордлого ихээр гарч байгаатай холбоотойгоор сургуулийн хоолны чанар, зохион байгуулалтыг сайжруулах асуудлаар субъектуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, зохион байгуулалтын талаарх мэдээлэл цуглуулах ажлыг Төрийн Думын орлогч даргын санаачилгаар эхлүүлсэн (2018 оны 1-р сарын байдлаар). Мэдээллийг цуглуулж дууссаны дараагаар хүнсний чанар, аюулгүй байдлыг сайжруулахтай холбоотой санал, дүгнэлтээ танилцуулахаа мэдэгдсэн байна. Сургуулийн хоолны асуудлаарх Парламентын ажлын хэсгийн хуралдаанаар сургуулийн хоолны үйлчилгээг тендert ялсан этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй байх, сургуулийн хоолны бэлтгэн, нийлүүлэлтийг хангалтгүй биелүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн “хар жагсаалт”-ыг хөтлөх, бэлтгэн нийлүүлэгчдэд тавих шаардлагуудыг чангатгах зэрэг саналуудыг хэлэлцсэн байна.

Словени Улсын хувьд сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг 2010 онд баталсан Сургуулийн хоолны тухай хуулиар зохицуулж байна. Сургуулийн хоолонд тохирохгүй, эсхүл бага давтамж болон бага хэмжээтэй олгох хүнс болон тэдгээрийг орлуулах эрүүл хүнсний жагсаалтыг баталсан. Сургуулиуд нь эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн сургалтыг агуулга, хөтөлбөрийг боловсруулдаг. Словенийн сургуулиуд нь Үндэсний удирдамжийн хүрээнд шим тэжээлийн хувьд тэнцвэртэй хоол хүнсээр хангах асуудлын хүрээнд жимс, ногооны долоо хоног, хоолны сургалт, хоол, хүнсний амталгаа, сургуулийн цэцэрлэг байгуулах, фермийн үйл ажиллагаатай танилцах болон орон нутгийн/дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжих зэрэг нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.



**Хүснэгт 1. Сургуулийн хоолны бие даасан хууль тогтоомж бүхий орнуудын эрх зүйн орчны харьцуулалт**

| Асуудал |                              | БНСУ  | Япон  | Словени   |
|---------|------------------------------|---|---|---|
| 1       | Хууль тогтоомжийн нэр        | <b>Сургуулийн хоолны тухай хууль</b> , 2006<br>Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журам  | <b>Сургуулийн үдийн хоолны тухай хууль</b> , 1954<br><b>Хоол, шим тэжээлийн боловсролын суурь хууль (Шокуики)</b> , 2005  | <b>Сургуулийн хоолны тухай хууль</b> , 2013   |
| 2       | Хуулийн зорилго              | Сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлж, сурагчдын оюун санаа, бие бялдрын хөгжилд хувь нэмэр оруулах, сургуулийн хоолны үйлчилгээгээр дамжуулан үндэсний хоолны дэглэмийг сайжруулах.   | Сургуулийн үдийн хоол нь хүүхдүүд, ялангуяа сургуулийн насын хүүхдийн оюун санаа, эрүүл бие бялдрыг хөгжүүлэх, хүүхдийн ойлгох чадварыг сайжруулахад зохих хувь нэмрийг оруулж байгаа нөхцөл байдлыг харгалзан үзсэний дүнд тус хуулийн зорилго нь сургуулийн үдийн хоолны шим тэжээлийг нэмэгдүүлэх, сургуулийн үдийн хоолонд тавигдах үндсэн шаардлага, зөвлөмжөөр хангах   | Энэхүү хуулийн зорилго нь сурагчдын сургуулийн хоолыг зохион байгуулах, сурагчдын хөнгөлөлттэй хоолоор хангах эрх, сургуулийн хоолонд олгох хөнгөлөлт, татаасын хэмжээ, нөхцөлийг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.   |
| 3       | Нэр томъёо                   | <b>"Сургуулийн хоолны үйлчилгээ"</b> гэж хуулийн зорилгод хүрэхийн тулд сургуулийн захирал, сурагч, сурагчдад 4-р зүйлд заасан хоолны үйлчилгээ;<br><b>"Сургуулийн хоолны үйлчилгээ эрхлэгч"</b> гэж 15-р зүйлийн дагуу сургуулийн захиралтай гэрээ байгуулсны дагуу сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг;<br><b>"Хоолны үйлчилгээний зардал"</b> гэж хоол хүнсний зардал, хоол хүнсний үйлчилгээний үйл ажиллагааны зардал, үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжийн бусад зардал зэргийг багтаана. | <b>"Сургуулийн үдийн хоол"</b> гэдгийг хуульд дурдсан зорилтыг хангах үүднээс бүх ерөнхий боловсролын сургууль дахь сурагч, оюутнуудад хүргэж байгаа хоолны үйлчилгээ; <b>"Заавал эзэмших суурь боловсрол олгох бүх сургуулиуд"</b> гэж Сургуулийн боловсролын тухай хуульд заасан бага, дунд сургууль, эсхүл тусгай хэрэгцээт боловсрол олгох бага, дунд сургуулиудыг хэлнэ. | <b>"Сургуулийн хоол"</b> гэж сургуулийн хичээлийн хуваарийн дагуу явагдах хичээлийн өдөр сургуулиас өгч буй хоолыг хэлнэ. Сургуулийн хоолонд өглөөний цай, үдээс өмнөх зууш, үдийн хоол, үдээс хойших зууш багтана.<br><b>"Бага, дунд сургуулийн үдийн цайны үнэ"</b> - сургуулиас сурагчдад санал болгож буй үдийн цайны үнийг хэлнэ. Хоолны үнийг хичээлийн жилийн эхэн бүрт Боловсролын асуудал хариуцсан сайд тогтооно. Сургуулийн хоолны бусад үйлчилгээний үнийг сургууль тогтооно. |
| 4       | Удирдлага, зохион байгуулалт | 15-р зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь сургуулийн хоолны үйлчилгээг шууд удирдан зохион байгуулах ба Сургуулийн үйл ажиллагааны хороотой хэлэлцэсний үндсэн дээр сургуулийн хоолны үйлчилгээг эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр өөр хүнд хариуцуулж болно. Зайлшгүй  | 4 дүгээр зүйлд заасны дагуу суурь боловсрол олгох сургуулийн үүсгэн байгуулагч бүр сурагчыг өөрийн сургууль дээр үдийн хоолоор хангах хүчин чармайлт гаргах ёстой гэж заасан байна.<br>5 дугаар зүйлд төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага нь сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийг хөгжүүлэх, түгээн  | Сургуулийн захирал нь сургуулийн хоол, шим тэжээлийн асуудлаар санал, зөвлөмж гаргах Хоол, шим тэжээлийн бүлэг (Nutrition group)-г томилж болно.<br>5-р зүйлд заасны дагуу Сургуулиуд нь хоол, хүнс худалдаж авах, боловсруулах, шаардлагатай мэдээллийг бүртгэх, хоол, шим тэжээлтэй холбоотой боловсролын үйл   |

| Асуудал | БНСУ   | Япон   | Словени   |   |
|---------|--|--|---|---|
|         | <p>шаардлагаас бусад тохиолдолд хоол, хүнсний бүтээгдэхүүн сонгох, худалдан авах, хянан шалгах үүргийг шилжүүлэхгүй.</p> <p><b>Сургуулийн хоолны үйлчилгээний хороо</b></p> <p>- Орон нутгийн Боловсролын албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөө, хоолны зардлын татаас болон холбогдох бусад асуудлаар тус хороог байгуулна.</p> <p><b>Сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороо</b> - Орон нутгийн захиргаа нь сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих асуудлуудыг хэлэлцэх зорилгоор байгуулж болно.</p> <p><b>Сургуулийн өдрийн хоол дэмжих төв</b> - Орон нутгийн захиргаа нь сургуулийн хоол хүнсний үйлчилгээг дэмжих хүрээнд сайн чанарын хоол хүнсний бүтээгдэхүүнээр хангах үүрэг бүхий төвийг байгуулж, ажиллуулж болно.</p> | <p>дэлгэрүүлэх талаар хүчин чармайлт үүрэгтэй болохыг заасан байна.</p> <p>6 дугаар зүйлд суурь боловсролын байгууллагын үүсгэн байгуулагч бүр 2 буюу түүнээс дээш сургуулийг үдийн хоолоор хангах гал тогоотой байж болно.</p> <p>14-р зүйлд энэ хуульд тусгаагүй хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газрын тогтоолоор тогтооно гэж заасан байна.</p>            | <p>ажиллагаа явуулах болон бусад ажлыг зохион байгуулна. Сургууль нь сургуулийн хоолны худалдан авалт, боловсруулалт болон түгээлт зэрэг үйлчилгээг бусад боловсролын байгууллагад шилжүүлж болох ба тус байгууллага нь энэхүү хуульд заасан журам, нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна. Онцгой тохиолдолд сургууль нь сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно. Ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа сургуулийн зөвлөлөөс урьдчилан зөвшөөрөл авсан байна.</p> |   |
| 5       | Хоол зүйч, хоолны шим тэжээлийн багш эсэх  | 7 дугаар зүйлд заасны дагуу сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон сургуулиуд нь <u>хоол зүй, шим тэжээлийн багш</u> , мэргэжлийн тогоочийг ажиллуулна.   | 7 дугаар зүйлд заасны дагуу сургуулиудын үдийн <u>хоолны шим тэжээл, гол тогоотой холбоотой мэргэжлийн асуудал хариуцсан ажилтан</u> нь Хоол зүй шим тэжээлийн багшийн лицензтэй, эсхүл Хоол зүйчийн тухай хуульд заасан Хоол зүйчийн лицензтэй байхаас гадна сургуулийн үдийн хоолны талаар шаардлагатай мэдлэг туршлагыг хуримтлуулсан байх ёстой.  | Тусгаагүй   |
| 6       | Хоол, шим тэжээлийн боловсрол  | <p>13 дугаар зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь сурагчдад зөв хооллолт, хоолны зөв дадал зуршил бий болгоход чиглүүлж, хоол, хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, уламжлалт хоол хүнсний соёлыг залгамжлуулж, эцэг, эхчүүдийг холбогдох мэдээллээр хангана.</p> <p>14 дүгээр зүйлд заасны дагуу Сургуулийн захирал нь хооллолт, хоолны дадал</p> | <p>10 дугаар зүйлд Хоол, шим тэжээлийн багш нь сурагчдад сургуулийн үдийн хоолоор дамжуулж хооллолтын заавар, зөвлөмж өгөх болон хоол хүнсний хэрэгцээт чанар, дэглэмийн талаарх ойлголтыг өгөх, энэ ойлголтыг хүүхдэд төлөвшүүлэх талаар сургуулийн захиргаанаас дэмжиж ажиллах ёстой. Хүүхдүүдэд эрүүл хооллолтын талаар мэдлэг мэдээлэл өгч, түүний ач тусын талаар</p>  | <p>Шим тэжээлийн боловсрол олгох тусгай хөтөлбөр байхгүй бөгөөд 4.7-д заасны дагуу сургууль нь жилийн төлөвлөгөөндөө сурагчдын эрүүл хооллолт, хоол, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагааг тусгана.</p> |

| Асуудал |   | БНСУ  | Япон   | Словени  |
|---------|---|---|--|--|
|         |   | зуршлаас үүссэн шим тэжээлийн өөрчлөлтийг бууруулах мөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс бага жинтэй, өсөлтийн хоцрогдол, цус багадалт, илүүдээл жин, таргалалт зэрэг хоол тэжээлийн зөвлөгөө шаардлагатай сурагчдад заавар, зөвлөгөөгөөр хангаж ажиллана.   | зэрэг ойлголттой болгохын тулд хоол, шим тэжээлийн багш өдрийн хоол тэдний эрүүл мэндэд хэрхэн сайнаар нөлөөлж буй талаар заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ тухайн бус нутгийн онцлог, өвөрмөц байдал, тухайн газар нутгийн хоолны соёл уламжлал, хоол үйлдвэрлэлийг танилцуулж, бус нутгийн онцлог бүтээгдэхүүний шим тэжээл, ашиг тусын талаар тухай бүр ойлголт өгөх ёстой байна.   |  |
| 7       | Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд дагаж мөрдөх стандарт, шаардлага | - Сургуулийн үдийн хоолны стандарт (НАССР);<br>- 2018 оны 9-р сарын 14-нөөс эхлэн сургуулийн орчинд кофе худалдахыг хориглосон. <sup>259</sup><br><br>Хуулийн 10, 11, 12-р зүйлүүдэд Хүнсний бүтээгдэхүүн, Хоол тэжээлийн менежмент, Ариун цэвэр, эрүүл ахуйн менежменттэй холбоотой асуудлыг тусгасан. Хоол, хүнсний аюулгүй байдал, шим тэжээл, эрүүл ахуйн шаардлагуудыг Боловсролын яамнаас баталсан журмаар тогтооно.<br><br>15-р зүйлд сургуулийн хоол, хүнс бэлтгэн нийлүүлэгчдэд тавигдах шаардлага болон Сургуулийн захирлын сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой эрхийг шилжүүлэхтэй холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоохоор заасан. | - НАССР;<br>Хуулийн 8, 9-р зүйлд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн сайд нь сургуулийн хоолны шим тэжээл, сургуулийн хоолны хөтөлбөр болон түгээлт зэргийг хэрэгжүүлэхтэй холбоотой стандартуудыг нарийвчлан тогтооно. Мөн яамнаас сургуулийн үдийн хоолыг бэлтгэх, гал тогоо, түүнд тавигдах тоног төхөөрөмж, ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох стандартыг баталж, мөрдүүлнэ. Сайд нь үдийн хоол бэлтгэн, үйлчилгээнд байр, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил, зохион байгуулалт, хоол хийх явцын эрүүл ахуй болон үдийн хоол түүний бусад эрүүл ахуйн менежменттэй холбоотой шаардлагатай асуудлуудыг биелүүлэн хангах стандартуудыг бий болгох үүрэгтэй. | - Сургуульд хоол, ундаа борлуулах автомат машин байрлуулахыг хориглосон.<br>4-зүйлд заасны дагуу Словенийн Шинжээчдийн зөвлөлөөс баталсан Ерөнхий боловсролын байгууллага дахь хооллолтын удирдамжийг баримтлах ба дараахыг тусгана. Үнд: сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой зорилго, баримтлах зарчим, боловсролын үйл ажиллагаа, хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, хоол төлөвлөх, хоолны хэмжээ болон бэлтгэх арга, хугацаа зэргийг тогтоосон Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас баталсан мэргэжлийн удирдамж, аргачлалууд. |
| 8       | Санхүүжилт, хөнгөлөлт   | Сургуулийн хоолны зардлыг эцэг, эх, үйлчилгээний зардлыг сургууль хариуцна.<br>8, 9 дүгээр зүйлд сургуулийн хоолны зардал, татаас, дэмжлэгтэй холбоотой асуудлыг тусгасан ба шаардлагатай тоног   | 11 дүгээр зүйлд сургуулийн гал тогоо тоног төхөөрөмжтэй холбогдох зардлыг сургууль, бусад зардлыг хүүхдийн эцэг, эх хариуцахаар тогтоож өгсөн байна.<br>12 дугаар зүйлд хувийн сургуулиуд Засгийн  | 7 дугаар зүйлд заасны дагуу Сургуулийн сургач буюу түүний эцэг, эх сургуулийн хоолны зардлыг хариуцна. Сургуулийн хоолны үнийг орон нутаг/хот, донор болон бусад эх үүсвэрээс хандив, санхүүжилт   |

<sup>259</sup> On March 13, 2018, an amendment to the Special Act on Safety Management of Children's Dietary Lifestyle was promulgated by the President of South Korea. (The amended Act will come into effect on September 14, 2018. (Act No. 15485 add.).

| Асуудал |                      | БНСУ   | Япон   | Словени  |
|---------|----------------------|--|--|--|
|         |                      | төхөөрөмжийн зардлыг сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч төр, орон нутгийн захиргаанаас татаас олгож болно. Хоолны үйлчилгээний зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч Ерөнхийлөгчийн захирамжид заасан зарим зардлыг эцэг, эх, асран хамгаалагч хариуцна.   | газраас тогтоосон журмыг биелүүлж буй тохиолдолд сургуулийн өдрийн хоол бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн болон байрны зардлыг санхүүжүүлэхэд тодорхой хэмжээний татаас олгож болно гэж заасан байна.<br>13 дугаар зүйлд олгосон татаасыг буцаан авах нөхцөлүүдийг тусгасан байна. | олгосон тохиолдолд бууруулж болно.<br>13 дугаар зүйлд заасны дагуу сургуулийн үдийн цайны татаас нь сургуулийн үдийн цайны үнийн 2/3-тай тэнцэх ба нэмэлтээр үдийн цайны 1/3-д татаас олгоно.<br>15-р зүйлд заасны дагуу сургуулийн хоолыг үнээр нь худалдан авах боломжгүй сурагчдад улсын төсвөөс татаас олгоно.<br>14, 18, 25, 26-р зүйлээр сургуулийн үдийн цай, хоолны дэмжлэгэд хамрагдах нөхцөл, шалгуур, дэмлэг, татаас олгохтой холбоотой асуудлыг зохицуулсан.   |
| 9       | Хяналтын тогтолцоо   | 18, 19 дугаар зүйлд Сургуулийн хоолны үйлчилгээний үнэлгээ, сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ авагдаж буй газар хяналт шалгалт хийх үйл ажиллагаатай холбоотой асуудлууд тусгагдсан. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сургуулийн хоолны үйл ажиллагааны үнэлгээ хийж болно. Хоолны эрүүл ахуй, эсхүл хоолны үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагчид Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны даргын зөвшөөрснөөр сургуулийн хоолны үйлчилгээнд хамаарах барилга байгууламжид нэвтэрч, хоол, хүнс, барилга байгууламж, бичиг баримт, үйл ажиллагааны нөхцөл байдалд үзлэг, шалгалт хийх, эсхүл хоол, хүнсний дээж авахыг шаардаж болно. Боловсролын сайд, Боловсролын албаны дарга нь илрүүлсэн зөрчлийг зогсоох, арилгуулах шаардлагыг сургуулийн захирал сургуулийн хоолны нийлүүлэгчид хүргүүлж болно. | Тусгаагүй  | 19-22 дугаар зүйлд дотоод болон хөндлөнгийн хяналттай холбоотой асуудлыг тусгасан. Үүнд:<br>- Сургуулийн хичээлийн жилийн хугацаанд сурагч, эцэг, эхчүүдээс сургуулийн хоолны чанар, хоол, шим тэжээлийн боловсролын асуудлаар сэтгэл ханамжийн судалгаа авах;<br>- Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ нь мэргэжлийн удирдамжуудад нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавих;<br>- Захирал нь ажил гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, илрүүлсэн зөрчлийг арилгуулах шаардлагыг ажил гүйцэтгэгчид бичгээр гаргана. Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгч шаардлагыг биелүүлээгүй бол сургууль нь гэрээгээ цуцална;<br>- Боловсрол, спортын хяналтын газар сургуулийн сургуулийн хоолны үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой холбоотой асуудлаар хяналт тавьж, бусад эрх бүхий хяналтын байгууллага нь төсвийн хяналт болон хувийн мэдээллийн ашиглалтад хяналт тавина. |
| 9       | Хариуцлагын механизм | 21-25 дүгээр зүйлээр захиргааны арга хэмжээ, сахилгын арга хэмжээ, шийтгэл   | - Тусгаагүй  | 23 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тусгасан.  |

| Асуудал | БНСУ   | Япон | Словени   |
|---------|--|------|---|
|         | <p>ногдуулах, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, торгууль зэрэг асуудлыг зохицуулсан.</p> <p>16, 19-р зүйлд заасан хоол, хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах, үзлэг шалгалт явуулахтай холбоотой зөрчил гаргасан этгээдэд 3-7 жилийн хорих ял, 30-100 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулахаар заасан байна. 24-р зүйлд хуулийн этгээдэд хариуцлага ногдуулах нөхцөлийг тусгасан байна. 25-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэл, шалтгаангүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 3-5 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулахаар заасан.</p> |      | <p>Сургуулийн байцаагч нь 1000-2000 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуульд, 500-1000 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг этгээдэд тус тус ногдуулна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зурсил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй;</li> <li>- Хоолны зардлыг холбогдох журмын дагуу тогтоогоогүй;</li> <li>- Хүнс, ундааны автомат машин суурилуулсан;</li> <li>- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;</li> <li>- Сургуулийн хоолны шим, тэжээлийн баримтжуулалт үйлдээгүй;</li> <li>- Сургууль нь төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч мэдээлэл бүрдүүлсэн;</li> </ul> <p>Сургуулийн байцаагч нь 100-200 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг хөнгөн гэмт хэрэг үйлдсэн сургуулийн ажилтанд ногдуулна.</p> |

## **НЭГ. СУРГУУЛИЙН ХООЛЫГ ЕВРОПЫН ЗАРИМ ОРОНД ЗОХИЦУУЛСАН ТУРШЛАГА**

**Болгар:** Сургууль (2009), цэцэрлэг (2011), ясли (2013) дахь Эрүүл хооллолтын тухай Эрүүл мэндийн сайдын тушаал, хууль эрх зүйн баримт бичиг тус бүрт зориулсан тусгай удирдамж бүхий номыг Эрүүл мэндийн яамнаас боловсруулсан. Эрүүл мэндийн яам болон 28 Бүсийн эрүүл мэндийн хяналтын газар /БЭМХГ/ (Regional Health Inspectorates) нь үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Олон нийтийн эрүүл мэнд, шинжилгээний үндэсний төв (National Center of Public Health and Analyses) нь БЭМХГ-ын ажилтнуудад зориулсан сургалтын арга зүй, сургалтын материалыг боловсруулж, сургалт явуулдаг. 28 БЭМХГ-с цэцэрлэг, сургуулийн ажилтнууд (захирал, эрүүл мэндийн ажилтан, гол тогооны ажилтан г.м.)-ад сургалт зохион явуулж, хүүхэд, сурагчдад эрүүл хооллолтын чиглэлээр төрөл бүрийн мэдээлэл, сурталчилгааны ажил, арга хэмжээ зохион байгуулдаг.

**Франц:** Сургуулийн хоолны асуудлыг Бага болон дунд сургуулийн тухай хууль, Цэцэрлэгийн тухай хуульд заасан Байгууллагын хоолны үйлчилгээний хүнсний стандартаар зохицуулсан. Сургуулийн хоолны чанар, шим тэжээлийн журмыг 2011 онд баталсан. Сургуулийн хоолны бэлтгэл, түгээлтийн асуудал нь муж бүрээр ялгаатай байх ба ихэнх тохиолдолд хоолыг сургууль дээр бэлтгэнэ. Цөөн тохиолдолд сургуулийн хоолыг гадуур буюу бэлтгэн нийлүүлэгч компани хариуцна.

**Финланд:** Сургуулийн хоолны асуудлыг Боловсролын тухай хууль тогтоомж, үндэсний болон орон нутгийн сургалтын хөтөлбөрүүдэд тусгасан байна. Сургалтын хөтөлбөрт эрүүл мэнд, шим тэжээл, хоолны соёлын боловсролын талаар тусгасан. 1948 оны Суурь боловсролын тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх болон бага, дунд сургуулийн сурагчдад сургуулийн хоолыг үнэгүй олгоно.

**Герман:** Одоогийн байдлаар улсын хэмжээнд заавал дагаж мөрдөх хүнсний стандарт байхгүй. Холбооны хоёр муж улсын нэгд нь сургуулийн хоолны газарт (Хоол тэжээлийн нийгэмлэгээс боловсруулсан) олон нийтийн хоолны чанарын стандартыг мөрддөг бол нөгөө муж улсад цэцэрлэгт олон нийтийн хоолны чанарын стандартыг мөрдөж байна. Дээрх стандартуудыг бусад муж улсад мөрдөх зөвлөмжийг гаргасан байна.

**Грек:** Зөвхөн зарим хувийн сургуулиуд сурагчдыг өдрийн хоолоор хангадаг. Эдгээр сургуулиудын хувьд 1999 онд Эрүүл мэндийн яамнаас баталсан Грекийн хоол тэжээлийн удирдамжийг үндэслэсэн Газар дундын тэнгисийн хоолны дэглэмийг баримталдаг.

**Ирланд:** Зөвхөн сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хоолны хөтөлбөр хэрэгждэг. 1991 онд батлагдсан Хүүхдийн асрамжийн тухай хууль болон 2016 оны тогтоолуудад “Бүртгэгдсэн үйлчилгээ үзүүлэгч нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхэд тус бүрт тохиромжтой, тэжээллэг хоол хүнс, ундаагаар хангана” гэж заасан байна.

**Испани:** Хоол, хүнсний сайн дураар мөрдөх стандартууд байдаг. Тухайлбал, Боловсролын төвүүд дэх хоолны зөвшилцлийн баримт бичиг (Consensus document on food in educational centres). Энэхүү баримт бичиг нь өдөрт авбал зохих илчлэгийн хэмжээ зэргийг сургуулийн хоолны шим тэжээлийн зөвлөмжид оруулах, сургуулийн орчинд хоолны газар, автомат машин болон түргэн үйлчилгээний цэгүүдэд зөв, эрүүл хоолны сонголт бий болгох шалгуур тогтоох зэрэгт чиглэсэн байна. Сургуулийн хоолны газрын тухай заалтууд 1990 оны Боловсролын тогтолцооны ерөнхий зохион байгуулалтын тухай хууль, 2006 оны Боловсролын тухай хуулиудад тусгагдсан. Сургуулийн удирдлага нь хоолны үйлчилгээгээр хангах асуудлыг хариуцна. Сургуулиуд нь хоолны үйлчилгээг өөрсдөө, эсхүл бэлтгэн нийлүүлэгчээр дамжуулан хэрэгжүүлдэг.

**Их Британи:** Сургуулийн удирдлага/ удирдах байгууллага нь сургуулийн хоолны үйлчилгээг Сургуулийн хоолны стандартад нийцүүлэн, хяналтыг ханган ажиллана. 2015 онд Сургуулийн хоолны төлөвлөгөөний хүрээнд батлагдсан дээрх стандартаар сургуулийн хоолны төрөл, хоол, хүнсний давтамж зэргийг тогтоосон.

**Латви:** 2012 оны Засгийн газрын 172 дугаар тогтоолоор “Боловсролын байгууллагын суралцагч, нийгмийн халамж болон нийгмийн нөхөн сэргээлтийн байгууллагуудын үйлчлүүлэгчид, эмчилгээний байгууллагуудын өвчтөнүүдийн шим

тэжээлийн стандартыг 2012 онд баталсан.

**Люксембург:** Сургуулиас гадуурх асрамжийн байгууллагуудаар (бүх хүүхдэд үйлчлэх) дамжуулан хоолоор хангадаг. Улсын хэмжээнд хоолны газруудын хоолны чанарыг сайжруулах, тогооч, сурган хүмүүжүүлэгч, багш нарын зөв хооллолт, шим тэжээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарал хандуулж байгаа. 2006 онд Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл ба Спортын сайд нарын хамтарсан тушаалаар Зөв хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

**Мальта:** “Эрүүл хооллолтын амьдралын хэв маягийн төлөвлөгөө” (сайн дурын)-г 2007 онд баталж, 2014 онд шинэчлэн найруулсан бөгөөд өдрийн хоолонд зөвшөөрсөн, хориглосон хүнсний жагсаалтыг багтаасан.

**Польш:** Эрүүл мэндийн сайдын 2015 оны 8-р сарын 26-ны тушаалаар Боловсролын орчинд хүүхэд, залуучуудыг хангаж буй хоол, хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлагыг баталсан. Одоогийн байдлаар бага сургуулийн 60%, дунд сургуулийн гуравны нэг нь үдийн хоол олгодог.

**Румын:** 2008 оны Эрүүл мэндийн яамны тушаал дугаар 1563, хавсралт 3, 4, 5-д өөр өөр наасны бүлгүүдэд тохирох илчлэгийн хэрэгцээ, хүнсний пирамид, хүнсний төрөл зэргийг тусгасан.

**Словак:** 2009 онд Боловсролын яамнаас баталсан Тунхагт сургуулийн хоолонд тавигдах шаардлагуудыг тусгасан. Сургуулийн хоолны газруудыг орон нутгийн удирдлагууд байгуулна. Сургуулийн тухай хуульд заасны дагуу сургуулийн хоолны газрууд нь хоол хүнс, ундаа бэлтгэх, үйлчилгээ үзүүлэх барилга, байгууламж байна. Сургуулийн хоолны газрууд нь үйлдвэрлэгч, түгээгч гэх хоёр хэлбэртэй байна. Үйлдвэрлэгч хоолны газарт сургуулийн хоолыг бэлтгэж, үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг бол түгээгч хоолны газруудад хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүнээр үйлчилдэг.

**Словени:** 2010 онд Словенийн сургуулийн хоолны тухай хууль батлагдаж, 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон. Тус хууль болон Цэцэрлэгийн эрүүл хооллолтын хоол тэжээлийн үндэсний удирдамжийн хүрээнд сургуулийн сурагч бүрт өдөрт нэг удаа шим тэжээлийн хувьд тэнцвэртэй үдийн цайгаар хангах Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн стандартуудыг баталсан. Сургуулийн хоол (үдийн цай/зууш, эсхүл өдрийн хоол) нь тохиромжтой болон тохиромжгүй хоолны бүлгийн жагсаалт болон илчлэг, шим тэжээлд тавигдах шаардлагад нийцсэн байна. Сургуулийн хоолонд тохирогчий, эсхүл бага давтамж болон бага хэмжээтэй олгох хүнсний жагсаалтыг баталж, орлуулах эрүүл хүнсний жагсаалтыг сургуулийн гал тогоонд олгодог. Тус хуулиар сургуулиуд өөрсдийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд оруулах эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн боловсрол, сургалтыг үйл ажиллагааны хэмжээ, агуулгыг тогтоож өгөхөөр зохицуулсан. Шим тэжээлийн хувьд тэнцвэртэй хоол хүнсээр хангах асуудлын хүрээнд Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөр нь жимс, ногооны долоо хоног зэрэг нэмэлт санаачилгудыг хэрэгжүүлдэг. Тус хөтөлбөр нь суурь боловсрол олгох байгууллагын сургачдын 90.5 хувийг хамарч байгаа бөгөөд сурагчдыг шинэ ногоо, жимсээр хангадаг, үүнээс хатаасан, эсхүл нөөшилсөн бүтээгдэхүүн 10 хүрэхгүй хувийг эзэлдэг байна. Үүнээс гадна шим тэжээлийн боловсрол, хоол хийж сурх хичээл, амталгаа, сургуулийн цэцэрлэг (жимс/ногооны талбай), тариалангийн талбайд очиж, танилцах болон орон нутгийн/дотоодын үйлдвэрийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авахыг дэмжих зэрэг нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Сургуулийн хоолны бэлтгэл, үйлдвэрлэл нь сургууль дээр, эсхүл гадуур явагдаж болдог. Сургуулийн болон орон нутгийн захиргаа нь сургуулийн хоолны үйлдвэрлэл сургууль дээр явагдаж байгаа тохиолдолд гал тогоогоор хангах, эсхүл гаднаас хоол авах тохиолдолд хоол, хүнсийг тогтмол нийлүүлэх гэрээт нийлүүлэгчээр хангах үүргийг хүлээнэ. Эрүүл, зөв хооллолтыг дэмжих бодлогын хүрээнд сургуулиудад хоол, ундаа борлуулдаг хүнсний автомат машинуудыг тавихыг хориглосон.

**Унгар:** Олон нийтийн хоолны тухай хууль нь 2014 онд батлагдаж, 2015 оны 9-р сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Тус хуульд олон нийтийн хоолны газруудад үйлчлэх хоол, хүнсний стандартуудыг тусгасан. Мөн хуулиар хоол тэжээлийн тоо, наасны ангилалд тохирох хоолны порц, 10 өдрийн туршид тодорхой хоол хүнсээр хангах давтамж, наасны ангилалд тохирох хоол, шим тэжээл, авбал зохих илчлэг зэргийг зохицуулсан байна.

Түүнчлэн тодорхой хүнс, бүтээгдэхүүнийг хэрэглэх журам, тэдгээрт тавигдах хязгаарлалт, хоригуудаас гадна тусгай хоолны дэглэмүүдэд зориулан үйлчилгээ үзүүлэх, мэдээллээр хангах (цэс, шошгонд тавигдах шаардлага) зэргийг тусгасан. Багш, эцэг, эх, сурагчдад зориулсан мэдээлэл, сурталчилгааны ажлууд болон нийтийн хоолны үйлдвэрлэгч нарт сургалт явуулдаг.


**Эстони:** Сургуулийн хоолны бодлого нь Боловсролын яамнаас 2008 онд боловсруулсан “Сургуулийн өмнөх боловсролын болон сургуулийн барилга байгууламжид тавигдах эрүүл ахуйн шаардлага”-аар зохицуулагддаг. Тус баримт бичгээр хоолны газар, өрөө тасалгаанд тавигдах шаардлагуудыг тогтоосон ба баримт бичгийг 2018 онд шинэчлэхээр төлөвлөсөн. Бага болон дунд сургуулийн сурагчдад сургуулийн хоолыг үнэгүй олгодог.

#### Европын орнуудын хувьд<sup>260</sup>:

- 53 хувь - сургуулийн орчинд хүнс, ундааны автомат машин байрлуулахыг хориглосон, эсхүл эрүүл хоол хүнсний сонголт бүхий хязгаарлалтуудыг тогтоосон;
- 76 хувь - хоол, хүнсний зар сурталчилгааг хориглосон;
- 68 хувь - хоол, шим тэжээлийн боловсрол нь заавал судлах хичээлийн хөтөлбөрт орсон;
- 65 хувь - хоол бэлтгэх, нийлүүлэх асуудал хариуцсан ажилтнуудад тусгай сургалт зохион байгуулдаг байна. Зарим улсад хоолны үйлдвэрлэлтэй холбоотой бүхий л ажилтан, бэлтгэн нийлүүлэгчдэд мэргэжлийн шаардлага, стандарт үйлчилдэг бол Итали, Латви, Швед зэрэг улсад дээрх шаардлагыг албажуулаагүй боловч зохих мэдлэг, чадвартай ажилтан байх ёстой гэж заасан байна. Сургуулийн хоолны бэлтгэн нийлүүлэлт хариуцсан ажилтанд мэргэжлийн сургалтад хамрагдсан байх шаардлага тавьдаггүй улсын тоонд Кипр, Чех, Ирланд, Литва, Нидерланд, Норвег, Португал болон Их Британи (Англи) орж байна.


Европын зарим орнуудад сургуулийн орчинд хүнсний автомат машиныг зохицуулсан байдал болон хоол, шим тэжээлийн боловсролыг хэрхэн зохицуулсныг доорх зургуудаас үзнэ үү.

Зураг 1. Сургуулийн орчинд хүнсний автомат машиныг зохицуулсан байдал



- хүнсний автомат машин байхгүй/ сургуульд байрлуулахыг хориглосон
- тодорхой хоол/ундааны зүйлийг хүнсний автоматаар худалдаалахыг хориглосон
- хүнсний автомат машинаар эрүүл хооллолтын стандартад нийцэн хүнс/ундаа борлуулдаг
- илүү эрүүл хүнс/ундаа борлуулах зөвлөмж гаргасан
- хүнсний автомат машинтай холбоотой хязгаарлалт байхгүй

Зураг 2. Хоол, шим тэжээлийн боловсрол олгодог байдал



- хоол, шим тэжээлийн боловсрол – сургуулийн хичээлийн хөтөлбөрт багтсан
- хоол, шим тэжээлийн боловсрол – сайн дурын

<sup>260</sup> ЕХ-ны 28 гишүүн орон болон Норвег, Швейцар

## **ХОЁР. СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХООЛНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛЖ БУЙ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

### **ЯПОН**

Японы одоогийн хэрэгжүүлж буй сургуулийн үдийн хоол хөтөлбөр нь 1954 онд батлагдсан "Сургуулийн үдийн хоолны тухай хууль"-ийн дагуу хэрэгжүүлж байна. Сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн үндсэн зорилго нь сургуулийн хүүхдүүдийн оюун ухаан болоод бие бялдрын эрүүл саруул хөгжлийг дэмжихийг чухалчилсан. Хожим нь "Сургуулийн үдийн хоолны тухай хууль"-ийг 2008 онд шинэчилсэн бөгөөд түүний гол зорилго нь "Шокуики"<sup>261</sup> (Food education) хуулийг дэмжих явдал байсан. Японы сургуулийн үдийн хоол маш эртний түүхтэй бөгөөд 1889 онд хүүхдийн анхны үдийн хоолонд будааны бөмбөлөг, давсалсан яргай загас, даршилсан ногоо өгч байсан байна. Сургуулийн үдийн хоолыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзвэл:

- 1889 он – Анх өдрийн хоол өгч эхэлсэн;
- 1946 он – НҮБ-ын хүүхдийн сан болон бусад байгууллагын сүүний хөтөлбөр хэрэгжсэн;
- 1947 он – 2,9 сая хүүхдэд үдийн хоол /хот/;
- 1949 он – Сургуулийн хоол /улс даяар/;
- 1954 он – Сургуулийн үдийн хоолны тухай хууль батлагдсан;
- 2005 он – Хоол хүнс болон хоол тэжээлийн багшийн системийг эхлүүлж мөн хоол хүнсний боловсролын суурь хууль батлагдсан байна.

Зарим шүүмжлэгчид хоолплох асуудал бол хувь хүний хэрэг тиймээс Засгийн газраас үүнийг хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үздэг боловч даяаршлын эрин үед уламжлалт хоолны соёлоо алдах, гадны хоол хүнснээс хэт хамааралтай болох, хүнсний аюулгүй байдалд учирч болох осол эндэгдэл, залуу эмэгтэйчүүдийн туранхай байх хүсэл, таргалалт, амьдралын хэв маягтай холбоотой өвчлөлийн өсөлт, тогтмол бус тэнцвэргүй хооплолт зэрэг хоол тэжээлтэй холбоотой маш олон санаа зовоосон асуудлууд хуулийн гадна байсан. Тиймээс эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзэн "Шокуику"-гийн хуулийг 2005 онд баталсан.

Тус хуулиар хоол, хүнсний тухай мэдлэгийг олж авах, эрүүл хооплолт, хоол, хүнсний зөв зохистой сонголт хийх чадвартай болгох хүрээнд "Хоол, хүнсний боловсролыг дэмжих ерөнхий төлөвлөгөө" гарган хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнээс гадна сургуулийн хүүхдүүдэд хоол тэжээлийн боловсролыг олгохын тулд Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам 2007 оны 4-р сард хоол зүй, шим тэжээлийн багшийн тогтолцоог бий болгосон.

Энэ ажлыг эхлүүлснээр хоол зүй, шим тэжээлийн багш нартай сургуулиудад багш, асран хамгаалагч болон хүүхдүүдийн дунд хоол тэжээлийн талаарх мэдлэг болоод сонирхлын хувьд маш олон эерэг үр дүн ажиглагдсан байна.

*Хоол, шим тэжээлийн багш нарын үүрэг:*

Өдөр тутмын сургуулийн үдийн хоолны менежментийн нэг хэсэг болгон хоол тэжээлийн удирдамжаар хангах.

- 1) Хоолны удирдамжаар ангийн багш нарыг хангаж, хамтран ажиллах;
- 2) Таргалалт, тохиромжгүй хоолны дэглэм, хоол хүнсний харшлаас урьдчилан сэргийлэх, арилгах талаарх удирдамжаар хангах;
- 3) Бусад багш, сурагч, гэр бүл, орон нутгийн иргэдтэй хамтран хоол тэжээлийн удирдамжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах;
- 4) Хоол тэжээл, эрүүл ахуй, нийлүүлэлтийг ханган ажиллах.

Сургуулийн Үдийн хоолны тухай хуулийг 2008 онд шинэчлэн боловсруулсны дараа хэд хэдэн шинэ зорилтыг нэмж, сургуулийн үдийн хоолыг хүүхдийн боловсролд чухал ач холбогдолтой болгосон. Японы сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн зорилго нь:

<sup>261</sup>Shokuiku, (Basic Law of Food and Nutrition Education), <http://www.maff.go.jp/e/pdf/shokuiku.pdf>

- 1) Зөв зохистой хоол хүнсийг хэрэглэх замаар хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлт гаргах;
- 2) Өдөр тутмын хоол хүнсний талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх, энэ ойлголтыг сайжруулах, эрүүл хоолны дэглэмийг бий болгох талаарх боломжийг хөгжүүлэх;
- 3) Зохистой сургуулийн амьдралаар амьдрах, нийгмийн эзэрэг орчинг бий болгох;
- 4) Хоол хүнс байгалиас хүн төрөлхтөнд зориулагдаж байдаг тул байгаль орчныг хамгаалах, өөрийн амьдралын үнэ цэнийг хүндлэх талаарх олон нийтийн ойлголт ухамсыг сайжруулах;
- 5) Хоол хүнс ямар олон хүмүүсийн хүч хөдөлмөрөөр бий болдог, тэрхүү хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгож хүндлэх талаарх ухамсар, ойлгоцыг төлөвшүүлэх, тэрхүү ойлголтыг нэмэгдүүлэх;
- 6) Япон болон бусад орны хоолны соёлын талаарх ойлголтыг таниулж, дээшлүүлэх;
- 7) Хоол хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хэрэглээ зарцуулалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

Сургуулийн хүүхдийн үдийн хоол хөтөлбөр нь өөрөө боловсролын үйл ажиллагааны нэг хэсэг юм. Сургуулийн хүүхдүүд өдрийн хоол идэх аяга таваг цэвэрлэх, ширээ засах, хоол аягалах зэрэг ажлыг өөрсдөө хариуцаж хийхээс гадна хүүхдүүд ангийнхантай хамт хооллож, цаашлаад зөв хооллолтын дэглэмийг сурч, зохистой хоолны дэглэм, хоолны соёлыг танин мэдэх зэрэгт суралцдаг байна.

Уг хуулийг хэрэгжүүлснээр өглөөний цайгаа алгасах хүүхдүүдийн тоо буурч, амьдралын хэв маяг сайжирч, сургуулийн хүүхдийн үдийн хоол хөтөлбөр нь хойч үедээ эрүүл саруул ухаан, бие махбодийг өвлүүлэн үлдээх чухал ач холбогдолтой хууль болсон хэмээн дүгнэсэн байна.

## **СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ**

**/SCHOOL LUNCH ACT<sup>262</sup>/**

**(1954 оны 6-р сарын 3-ны 160 дугаар хууль)<sup>263</sup>**

Японы “Сургуулийн үдийн хоолны тухай хууль” нь анх 1954 онд батлагдаж, сүүлийн байдлаар 2015 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд 14 зүйл бүхий хуулиар зохицуулж байна. Тус хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.

1 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоол нь хүүхдүүд, ялангуяа сургуулийн насны хүүхдийн оюун санаа, эрүүл бие бялдрыг хөгжүүлэх, ялангуяа хүүхдийн ойлгоцыг сайжруулахад зохих хувь нэмрийг оруулж байгаа нөхцөл байдлыг харгалзан үзсэний дунд тус хуулийн зорилго нь сургуулийн үдийн хоолны шим тэжээлийг нэмэгдүүлэх, сургуулийн үдийн хоолонд тавигдах үндсэн шаардлага, зөвлөмжөөр хангах нь тус хуулийн зорилго юм.

2 дугаар зүйлд хуулийн зорилтыг дараах байдлаар тодорхойлсон байна. Ерөнхий боловсролын сургуулийн зорилгыг хангах үүднээс сургуулийн үдийн хоолны талаар дараах зорилтод хүрнэ.

- 1) Зөв зохистой хоол хүнсийг хэрэглэх замаар хүүхдийн эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлт гаргах;
- 2) Өдөр тутмын хоол хүнсний талаарх зөв ойлголтыг төлөвшүүлэх, энэ ойлголтыг сайжруулах, эрүүл хоолны дэглэмийг бий болгох талаарх боломжийг хөгжүүлэх;
- 3) Зохистой сургуулийн амьдралаар амьдрах, нийгмийн эзэрэг орчинг бий болгох;
- 4) Хоол хүнс байгалиас хүн төрөлхтөнд зориулагдаж байдаг тул байгаль орчныг хамгаалах, өөрийн амьдралын үнэ цэнийг хүндлэх талаарх олон нийтийн ойлголт ухамсыг сайжруулах;
- 5) Хоол хүнс ямар олон хүмүүсийн хүч хөдөлмөрөөр бий болдог, тэрхүү хөдөлмөрийн үнэ цэнийг ойлгож хүндлэх талаарх ухамсар, ойлгоцыг төлөвшүүлэх, тэрхүү ойлголтыг нэмэгдүүлэх;

<sup>262</sup> school lunch act, <http://school-lunch-support.jp/en/act/>

<sup>263</sup> Хамгийн сүүлд 2015 оны 6-р сарын 24-нд нэмэлт өөрчлөлт орсон. № 46

- 6) Японы болон бусад орны хоолны соёлын талаарх ойлголтыг таниулж, дээшлүүлэх;
- 7) Хоол хүнсний үйлдвэрлэл, түгээлт, хэрэглээ зарцуулалтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

3 дугаар зүйлд “сургуулийн үдийн хоол” гэдгийг дээр дурдсан зорилтыг хангах үүднээс бүх албан журмын боловсролын сургууль дахь сургач, оюутнуудад хүргэж байгаа хоолны үйлчилгээ гэж тодорхойлсон байна.

4 дүгээр зүйлд суурь боловсролын сургуулийн үүсгэн байгуулагч бүр сургачдыг өөрийн сургууль дээр үдийн хоолоор хангах хүчин чармайлт гаргах ёстой гэж заасан байна.

5 дугаар зүйлд төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага нь сургуулийн үдийн хоолны хөтөлбөрийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх талаар хүчин чармайлт гаргах үүрэгтэй болохыг заасан байна.

6 дугаар зүйлд 2 буюу түүнээс дээш сургуульд үдийн хоолоор хангах бол сургуулийн гал тогоог нээн ажиллуулж болно гэж заажээ.

7 дугаар зүйлд хоолны шим тэжээл, дэглэмийн талаарх зохих мэргэжил бүхий ажилтан сургуульд ажиллах талаар заасан. Сургуулиудын үдийн хоолны шим тэжээл, гал тогоотой холбоотой мэргэжлийн асуудал хариуцсан ажилтан (“сургуулийн өдрийн хоолны мэргэжилтэн” гэх) нь Боловсролын байгууллагын ажилтныг гэрчилгээжүүлэх тухай хууль (Education Personnel Certification act)-ийн 4 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу Хоол зүй, шим тэжээлийн багшийн лицензтэй, эсхүл Хоол зүйчийн тухай (Dietitians act) хуулийн 2 дугаар зүйлийн нэгд заасан Хоол зүйчийн лицензтэй байхаас гадна сургуулийн үдийн хоолны талаар шаардлагатай мэдлэг туршлагыг хуримтлуулсан байх ёстой.

8 дугаар зүйлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нь сургуулийн хоолны шим тэжээл, хэмжээ зэрэг холбогдох стандарт журмыг баталж мөрдүүлэхээр заасан байна.

9 дүгээр зүйлд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд нь сургуулийн үдийн хоолыг бэлтгэх, гал тогоо, түүнд тавигдах тоног төхөөрөмж зэрэг ариун цэвэр, эрүүл ахуйн холбогдох стандартыг баталж, мөрдүүлэх үүрэгтэйг заасан байна. Үүнд: Сайд нь үдийн хоол бэлтгэн, хангах байр, тоног төхөөрөмжийн бэлтгэл ажил, зохион байгуулалт, хоол хийх явцын эрүүл ахуй болон үдийн хоол түүний бусад эрүүл ахуйн менежменттэй холбоотой шаардлагатай асуудлуудыг биелүүлэн хангах стандартуудыг бий болгох үүрэгтэй.

10 дугаар зүйлд Хоол, шим тэжээлийн багш нь сургачдад сургуулийн үдийн хоолоор дамжуулж хооллоптын заавар, зөвлөмж өгөх болон хоол хүнсний хэрэгцээт чанар, дэглэмийн талаарх ойлголтыг өгөх, энэ ойлголтыг хүүхдэд төлөвшүүлэх талаар сургуулийн захиргаанаас дэмжиж ажиллах ёстой.

Хүүхдүүдэд эрүүл хооллоптын талаар мэдлэг мэдээлэл өгч, түүний ач тусын талаар эерэг ойлголттой болгохын тулд хоол, шим тэжээлийн багш өдрийн хоол тэдний эрүүл мэндэд хэрхэн сайнаар нөлөөлж буй талаар заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ тухайн бус нутгийн онцлог, өвөрмөц байдал, тухайн газар нутгийн хоолны соёл уламжлал, хоол үйлдвэрлэлийг танилцуулж, бус нутгийн онцлог бүтээгдэхүүний шим тэжээл, ашиг тусын талаар тухай бүр ойлголт өгөх ёстой байдаг байна.

11 дүгээр зүйлд сургуулийн гал тогоо тоног төхөөрөмжтэй холбогдох зардлыг сургууль, бусад зардлыг хүүхдийн эцэг, эх хариуцахаар тогтоож өгсөн байна.

12 дугаар зүйлд хувийн сургуулиуд Засгийн газраас тогтоосон журмыг биелүүлж буй тохиолдолд сургуулийн өдрийн хоол бэлтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн болон байрны зардлын тодорхой хэмжээний татаас олгож болохыг заасан байна.

13 дугаар зүйл. Дээрх заалтад дурдсаны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд дараах тохиолдолд улсаас олгосон татаасыг буцаан төлөхийг шаардаж болдог байна.

- Татаасыг зориулалтын дагуу ашиглаагүй;

- Татаасыг олгосноос хойш жилийн хугацаанд хүндэтгэх шалтгаангүйгээр дурдсан тоног төхөөрөмж болон материалаа аваагүй тохиолдолд;
- Заасан байгууламж, тоног төхөөрөмжийг өөр зорилгоор ашиглах;
- Татаас олгох нөхцөлийг зөрчсөн тохиолдолд;
- Хууран мэхлэх замаар татаас авсан буюу авахыг оролдсон үед.

14 дүгээр зүйлд Энэхүү хуульд зааснаас гадна хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, бусад арга хэмжээг засгийн газраас тогтоохоор заажээ.

### **СУРГУУЛИЙН ҮДИЙН ХООЛНЫ ХЭРЭГЖҮҮЛЭХ СТАНДАРТ<sup>264</sup>**

1 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоол нь сургуулийн үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуульд суралцаж буй хүүхэд, сурагчдад хамаарна.

(Сургуулийн үдийн хоолны тоо)

2 дугаар зүйл. Сургуулийн үдийн хоолыг хичээлийн жилийн турш долоо хоногт 5 удаа буюу үдийн цайны цагаар хэрэгжүүлнэ.

(Сургуулийн хүүхэд бүрийн эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэх)

3 дугаар зүйл. Сургуулийн үдийн хоолны тухайд сургуулийн хүүхдийн амьдралын идэвх, бус нутгийн нөхцөл байдал, эрүүл мэндийн байдлыг нэг бүрчлэн харгалзан үзнэ.

(Сургуулийн үдийн хоол хөтөлбөр дэх хоол тэжээлийн зураглал)

4 дүгээр зүйл. Сургуулийн үдийн хоолон дахь хоол тэжээлийн стандарт нь доорх хүснэгтэд харуулснаар нэг хүүхэд, сургуулийн хүүхдэд оногдох өдрийн хэрэглээний стандартад тулгуурлана.

*Хүснэгт 2. Сургуулийн үдийн хоолны нэг хүүхдийн өдрийн хэрэглээний стандарт*

| Шим<br>тэжээлийн орц | Стандарт хэмжээ                                  |             |             |             |
|----------------------|--|-------------|-------------|-------------|
|                      | 6-7 нас  | 8-9 нас     | 10-11 нас   | 12-14 нас   |
| Илчлэг (ккал)        | 530  | 640         | 750         | 820         |
| Үүраг                | 20<br>16-26                                      | 24<br>18-32 | 28<br>22-38 | 30<br>25-40 |
| Өөх тос              | Сургуулийн үдийн хоолны энергийн хэрэглээ 25-30% |             |             |             |
| Натри                | 2-с доош   | 2,5- с доош | 2,5-с доош  | 3-с доош    |
| Кальци               | 300  | 350         | 400         | 450         |
| Төмөр                | 2  | 3           | 4           | 4           |
| Витамин А            | 150  | 170         | 200         | 300         |
| Витамин В1           | 0,3  | 0,4         | 0,5         | 0,5         |
| Витамин В2           | 0,4  | 0,4         | 0,5         | 0,6         |
| Витамин С            | 20   | 20          | 25          | 35          |
| Ислэг                | 4  | 5           | 6           | 6,5         |

Дээрх хүснэгтээс гадна дор дурдсан зүйлсийг анхаарч хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- Магни - Сурагч (6-7 настай) 70мг;  
Сурагч (8-9 настай) 80мг;  
Сурагч (10-11 настай) 110мг;  
Сурагч (12-14 настай) 140мг;
- Цайр - Сурагч (6-7 настай) 2мг;  
Сурагч (8-9 настай) 2мг;  
Сурагч (10-11 настай) 3мг;  
Сурагч (12-14 нас) 3мг.

<sup>264</sup> <http://school-lunch-support.jp/en/implementation-standards/>

Энэ стандарт нь улсын дундаж үзүүлэлтийг харуулж байгаа ба сургууль тус бүр хүүхэд, сургуулийн хүүхдүүдийн эрүүл мэнд, амьдралын хэв маяг, бус нутгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж уян хатан үйл ажиллагаа явуулах ёстай.

## **БНСУ**

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-д сургуулийн үдийн хоол хөтөлбөрийг Сургуулийн хоолны тухай хууль<sup>265</sup>, Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журам<sup>266</sup>, Бага болон дунд боловсролын тухай хууль, Хүнсний эрүүл ахуйн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг байна. Сургуулийн хоолны тухай хуулийг 1981 онд баталсан бөгөөд үүнээс хойш хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оруулж, 2006 онд тус хуулийг бүрэн өөрчилсэн байна.

Анх 1953 онд Солонгосын дайны дараа НҮБ-ын Хүүхдийн сан (UNICEF), CARE, USAID зэрэг олон улсын тусlamжийн байгууллагууд болон Канад Улсын Засгийн газрын тусlamжтайгаар сургуулийн үдийн хоолыг өгч эхэлсэн байна.

Сургуулийн өдрийн хоолны аюулгүй байдлыг хангах, цаашдын хөгжлийг дэмжихийн тулд хууль батлах шаардлагатай болсон байна. Тусlamжийн өдрийн хоолноос хүүхдийн физиологийн хэрэгцээг хангахайц шим тэжээллэг өдрийн хоол руу шилжиж сургачийн эрүүл мэндийг сайжруулах болон ард иргэдийн хоолны дадал, зуршлыг өөрчлөхөд хувь нэмэр оруулах үүднээс Засгийн газрын санаачилгаар 1981 онд Сургуулийн хоолны тухай хуулийг баталсан байна. Тус хуулийн зорилго нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлснээр сургачдын оюун ухааны болон биеийн хөгжлийг сайжруулж, үндэсний хэмжээнд хооллох зөв дадлыг дэмжиж, ард иргэдийн эрүүл мэндийг сайжруулах зэрэг болно.

Тус хуулийн гол агуулга нь:

- Улс болон орон нутгийн удирдах шатны байгууллага нь сургуулийн өдрийн хоолны үйлчилгээг жигд, тогтмол хэрэгжүүлэхийн төлөө санаачилгатай ажиллах;
- Сургуулийн өдрийн хоолны хөтөлбөрт бүх бага сургуулиуд, Боловсрол, Соёлын яамны сайдын шаардлагатай гэж үзсэн (дунд болон ахлах) сургуулийг хамруулах;
- Сургуулийн өдрийн хоолны гал тогоо, тоног төхөөрөмж болон хэрэглэлээр хангах;
- Сургуулийн өдрийн хоол хэрэгжүүлэгч сургуульд хоол зүйч томилон ажиллуулах;
- Сургуулийн өдрийн хоолны барилга, байгууламж, тоног төхөөрөмж, үйл ажиллагааны зардал, хөдөлмөрийн хөлсийг сургуулийг үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах, хүнсний түүхий эдийн зардлыг асран хамгаалагч хариуцах зэрэг болно.


Бага, дунд, ахлах болон тусгай сургуулийн үдийн хоолны үйлчилгээ 1991 онд 13.3%-тай байсан бол 2003 оны байдлаар бараг 100%-д хүрсэн байна. 2010 оны байдлаар улсын хэмжээнд 11,396 сургууль буюу нийт сургуулийн 99.9% нь хүүхдүүдэд үдийн хоолоор үйлчилж (Зураг 3.), 7,263,000 сургач буюу 98.8% өдөр бүр сургууль дээрээ үдийн хоолоор үйлчлүүлсэн байна. Бараг ихэнх дунд сургуулиуд үдийн хоолоор үйлчилж байгаа боловч цөөн хэдэн дотуур байртай сургууль сургачиддаа өглөөний цай өгдөг байна.

- 1953~1972 онуудад ядуу өрхийн бага сургуулийн сургачдыг үнэгүй өдрийн хоолоор хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэв (нийт сургачдын гуравны нэг).
- 1981 онд Сургуулийн хоолны тухай хууль батлагдсанаас хойш алслагдсан орон нутгийн бага сургуульд үнэгүй өдрийн хоолны үйлчилгээг хэрэгжүүлж, газар тариалан, загасчлалын бүсийн хүнсний зардлын 1/3 хангав.
- 1988 оноос ядуу өрхийн бага сургуулийн сургачидыг үнэгүй өдрийн хоолоор хангаж эхэлсэн.
- 1997 оноос ядуу өрхийн дунд, ахлах сургуулийн сургачдыг үнэгүй өдрийн хоолоор хангаж эхэлсэн.
- 2011 оноос орон нутагт бүрэн үнэгүй өдрийн хоолоор хангадаг болсон.

<sup>265</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=29851&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=29851&lang=ENG)

<sup>266</sup> [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=31660&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=31660&lang=ENG)

Зураг 3. БНСҮ-ын Сургуулийн үдийн хоол үйлчилгээ /1991-2010/<sup>267</sup>



**Тайлбар:** Үдийн хоолоор үйлчилж буй сургуулийн хувь  
Үдийн хоолоор үйлчилж буй сургуулийн тоо

Сурагчдыг үдийн хоолоор хангах асуудлыг янз бүрээр шийдвэрлэж ирсэн байна. Орон нутгийн байгууллага ба эцэг, эхийн оролцоонд тулгуурлан алслагдсан орон нутгийн бүх сурагчид болон нэн ядуу өрхийн хүүхдүүдэд үнэгүй өдрийн хоолоор үйлчлэх, хотын сургуулиудад гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех байгуулах, орон нутгийн сургуулиудад фермийн аж ахуй эрхлэлтээр (гахай, тахиа үргүүлэг, хүнсний ногоо тариалалт гэх мэт) дамжуулан бие даасан өдрийн хоолны үйлдвэрлэл үйлчилгээг бий болгох зэргээр шийдвэрлэж ирсэн байна.

Сургуулийн өдрийн хоолны тогтолцоог бэхжүүлэх талаар олон төрлийн ажлууд хийгдсээр ирсэн бөгөөд мэргэшсэн хоол зүйчийг томилж ажиллуулах, сургуулийн өдрийн хоолны үр дүнтэй холбоотой судалгаа (өдрийн хоол өгдөг болон өгдөгтүй сургуулийн сурагчдын биеийн өндөр, жингиийн харьцуулалт, сурлагын дүн, өвчлөлийн хувь, хичээл таслалтын хувь, сургуулийн өдрийн хоолны сэтгэл ханамж гэх мэт), сургуулийн өдрийн хоолны стандартын цэстэй холбоотой судалгаа, сургуулийн өдрийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн судалгаа зэрэг судалгаа шинжилгээнүүдийг хийж 1977 онд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулах зарчим, төрөл, хэрэгжүүлэлтийн стандарт зэргийг нарийвчлан журамласан байна.

1996 онд Сургуулийн хоолны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр хоол хүнс үйлдвэрлэгч компаниуд гэрээгээр сургуулийн үдийн хоолны үйлчилгээ үзүүлэх эрхтэй болсон бөгөөд дунд болон ахлах ангийн сурагчид өдөр сургууль дээрээ хооллох боломжтой болсон байна. Сургуулиуд хоол, хүнс үйлдвэрлэгч компаниудтай үдийн хоолны гэрээ байгуулах нь эрс нэмэгдсэн ба 2004 оны байдлаар нийт сургуулиудын 17% хамрагдсан байна. 2006 онд олон тооны сурагчдыг хамарсан хоолны хордлого гарснаас улбаалан “Сургуулийн хоолны тухай” хуулийг шинэчлэх шаардлага гарсан байна. Хуулийг шинэчлэн найруулсны үр дүнд олон сургуулиуд хоол хүнс үйлдвэрлэгч компаниудтай байгуулсан гэрээгээ цуцалж, сургууль дотроо өдрийн хоол үйлдвэрлэх болсон байна. 2010 оны байдлаар нийт сургуулиудын 5% хоол хүнс үйлдвэрлэгч компаниудтай үдийн хоолны гэрээтэй ажилласан байна. Мөн хоол, шим тэжээлийн багшийн орон тоог бий болгохор хуульд заасны дагуу 2007 оноос сурагчдын эрүүл мэнд ба хооллох зөв дадал, зуршил бий болгох, мэдлэг өгөх үүднээс системтэй шим тэжээлийн сургалтыг хэрэгжүүлэхийн тулд хүнсний эрүүл ахуйч гэгдэж байсан сургуулийн хоол зүйчийг хоол, шим тэжээлийн багшийн үүрэгтэйгээр албажуулсан байна.

Сургуулийн хоолны тухай хуулийн 5 дугаар зүйлд Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийн талаар хуульчилсан бөгөөд БНСҮ-ын муж, хот, аймаг, дүүргийн засаг дарга нар нь сургуулийн өдрийн хоолонд аюулгүй, чанартай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэхэд хүнсний

<sup>267</sup> [https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012\\_scs](https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs)

үйлдвэрлэл, нийлүүлэлт, төсвийг ил тод удирдах тогтолцоо юм гэжээ. Хоол, хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон нийлүүлэгчид Сургуулийн өдрийн хоол дэмжих төвөөр дамжуулан сургуульд нийлүүлдэг байна. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийлүүлэх компанийг Хүнсний эрүүл ахуйн тухай хуулийн дагуу сонгон шалгаруулдаг байна. Хуульд зааснаар, хүнсний стандартад тохирсон орчин, хөргөгч, хөлдөөгчтэй хадгалах байгууламж, хөргөгч, хөлдөөгч хөргүүр бүхий автомашин, ажилчдын эрүүл ахуй зэрэг үнэлгээ хийгдсэн байх шаардлагатай бөгөөд уралдаант шалгаруулалтаар (тендер) сонгон шалгаруулж, хамгийн бага үнийн санал болгосон компаний Сургуулийн хоолны үйлчилгээний хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанарын стандартын дагуу аюулгүй, чанартай, хүнсний түүхий эд ханган нийлүүлэх гэрээг байгуулдаг байна. Хүнсний бүтээгдэхүүний чанарын стандартыг Сургуулийн хоолны тухай хуулийг хэрэгжүүлэх журмаар тогтоосон байна.

### Хүснэгт 3. Сургуулийн өдрийн хоолны хүнсний бүтээгдэхүүний чанарын стандарт<sup>268</sup>

|                             |   |
|-----------------------------|---|
| Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн | Органик хүнс, бордоогүй хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний стандартын журмаар “сайн” зэрэглэлээс дээш, тэргүүний зохицуулалттай нотлогдсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, гарал үүслийн байдал тодорхой хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, цагаан будаа нь 1 жилийн доторх ургац гэх мэт |
| Мал аж ахуйн бүтээгдэхүүн   | НАССР <sup>269</sup> хангасан нядалгааны газар ба НАССР хангасан мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрт бэлтгэсэн үхрийн мах нь 3-р зэргээс дээш, гахайн мах нь 2-р зэргээс дээш гэх мэт   |
| Далайн бүтээгдэхүүн         | Газар зүйн тэмдэглэгээ бүхий далайн бүтээгдэхүүн, барааны чанар “сайн” –аас дээш  |
| Боловсруулсан бүтээгдэхүүн  | Уламжлалт хүнс гэдэг нь нотлогдсон бүтээгдэхүүн, чанарын баталгаатай, НАССР хангасан байгууллагад үйлдвэрлэсэн гэх мэт  |
| Бусад                       | Гарал үүслийн тэмдэглэгээтэй хүнс хэрэглэх,<br>Экспортын хүнс нь дээрх стандартад тохирох чанарыг хангасан байна  |

2010 оны байдлаар бага сургуулийн сурагчдын үдийн хоолны дундаж үнэ 1900 вон буюу (1.76 ам доллар), харин дунд болон ахлах сургуулийн сурагчдынх 2700 вон (2.5 ам доллар) байсан байна. 2011 оны байдлаар нийт сургуулийн 79% сургууль доторх хоолны газраараа үйлчилж, 16% нь ангидаа, үлдсэн 5% нь сургууль доторх хоолны газрын багтаамжаас шалтгаалж хоолны газар болон ангидаа хоолплоцгосон байна.

Анх буюу 1953 оны үед сургуулийн өдрийн хоолны цэсэнд:

- Сүү, эсхүл эрдэнэшишийн зутан;
- Гурилтай шөл, талх, эсхүл хатаасан талх орж байв.

Ерөнхийдөө Солонгос Улсын ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны цэсэнд агшаасан будаа, шөл, эсхүл жигнэсэн мах, уургаар баялаг хачир, нэмэлт хачир (-ууд), дарсан байцаа болон амттан ордог байна. Үдийн хоолтой хамт юмуу, эсхүл үдийн хоолноос хэдэн цагийн өмнө цэвэр сүү өгдөг байна. 2007 онд батлагдсан Сургуулийн хоолны тухай хуулийг дагаж мөрдөх журамд хүүхдийн насны ангилал, хүйсэнд тохируулж хоолны илчлэг, уураг амин дээмийн хэмжээг нарийвчлан тогтоосон байна. Сурагчдын үдийн хоолны цэсэнд шим тэжээлийг тэнцвэржүүлсэн хоол өгөхөөс гадна:

<sup>268</sup> БНСУ-д сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ (CXYY)-г хэрэгжүүлсэн арга зам, тогтолцоо: эрхзүйн орчин ба хяналт, үнэлгээ илтгээ

<sup>269</sup> HACCP-Hazard Analysis Critical Control Point (Аюулын дүн шинжилгээ ба эзээгтэй цэгийн хяналт тогтолцоо-хүнсний аюулгүй байдал баталгаажуулах тогтолцоо)

- Солонгос үндэсний уламжлалт хоолны соёлыг хадгалах;
- олон төрлийн үр тариа, жимс, ногоо, загас, мах, буурцаг, шош, вандуй, сүү, сүүн бүтээгдэхүүнийг багтаах;
- давс, тос, өөх, сахар болон хүнсний нэмэлтийг хэтрүүлэн хэрэглэхгүй байх;
- байгалийн гаралтай, улирлын чанартай хоолыг түлхүү хэрэглэх;
- олон төрлийн хоол хийх аргыг ашиглах шаардлагатай гэсэн байна.

Сургуулийн хоолны шим тэжээлийн стандарт нь дараах байдалтай байна. Үүнд:

- Илчлэгийн зохицуулалт:*
  - нүүрс ус: уураг: өөх-тосны илчлэгт эзлэх хувь = 55~70%:7~20%:15~30%
- Шим тэжээлийн тэмдэглэл болон хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийн тэмдэглэл:*
  - сургуулийн өдрийн хоолны цэс бүрээр шим тэжээлийн агууламж тооцож, хоолны газар болон ангийн самбарт байршуулах, мэдээлэх;
  - сургуулийн өдрийн хоолны цэсэнд ашиглагдсан хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тэмдэглэж самбарт байршуулах, мэдээлэх.
- Натрийн хэрэглээг багасгах (2017 оны зорилт):*
  - бага анги: 900 мг, дунд анги: 1,000 мг, ахлах анги: 1,300 мг.
- Харшил үүсгэгч хүнсний тэмдэглэгээ:*
  - цэсэн дэх харшил үүсгэх хүнсний тэмдэглэгээг сар бүрээр цэс, шим тэжээлийн мэдээллийн хамт хүүхдийн гэр лүү явуулах, сургуулийн сайтанд байршуулах;
  - харшилтай сурагчид орлох цэсийг бэлдэх шаардлага тавигддаг байна.

#### Хүснэгт 4. Сургуулийн хоолны шим тэжээлийн зохицуулалтын стандарт

| Ангилал | Анги                   | Илчлэг<br>(ккал) | Уураг<br>(г) | Витамин A (R.E) |                | Тиамин (витамин B <sub>1</sub> ) (мг) |                | Рибофлавин (витамин B <sub>2</sub> ) (мг) |                | Витамин C (мг) |                | Кальци (мг)   |                | Төмөр (мг)    |                |
|---------|------------------------|------------------|--------------|-----------------|----------------|---------------------------------------|----------------|---|----------------|----------------|----------------|---------------|----------------|---------------|----------------|
|         |                        |                  |              | Дундаж хэмжээ   | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ                         | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ                             | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ  | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ | Дундаж хэмжээ | Зөвлөмж хэмжээ |
| Эрэгтэй | Бага сургууль 1~3 анги | 534              | 8.4          | 97              | 134            | 0.20                                  | 0.24           | 0.24                                      | 0.30           | 13.4           | 22.0           | 184           | 234            | 2.4           | 3.0            |
|         | Бага сургууль 4~6 анги | 634              | 11.7         | 127             | 184            | 0.27                                  | 0.30           | 0.30                                      | 0.37           | 18.4           | 23.4           | 184           | 267            | 3.0           | 4.0            |
|         | Дунд сургууль          | 800              | 16.7         | 167             | 234            | 0.34                                  | 0.40           | 0.44                                      | 0.50           | 25.0           | 33.4           | 267           | 334            | 3.0           | 4.0            |
|         | Ахлах сургууль         | 900              | 20.0         | 200             | 284            | 0.37                                  | 0.47           | 0.50                                      | 0.60           | 28.4           | 36.7           | 267           | 334            | 4.0           | 5.4            |
| Эмэгтэй | Бага сургууль 1~3 анги | 500              | 8.4          | 90              | 134            | 0.17                                  | 0.20           | 0.20                                      | 0.24           | 13.4           | 20.0           | 184           | 234            | 2.4           | 3.0            |
|         | Бага сургууль 4~6 анги | 567              | 11.7         | 117             | 167            | 0.24                                  | 0.27           | 0.27                                      | 0.30           | 18.4           | 23.4           | 184           | 267            | 3.0           | 4.0            |
|         | Дунд сургууль          | 667              | 15.0         | 154             | 217            | 0.27                                  | 0.34           | 0.34                                      | 0.40           | 23.4           | 30.0           | 250           | 300            | 3.0           | 4.0            |
|         | Ахлах сургууль         | 667              | 15.0         | 167             | 234            | 0.27                                  | 0.34           | 0.34                                      | 0.40           | 25.0           | 33.4           | 250           | 300            | 4.0           | 5.4            |

# СУРГУУЛИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ /SCHOOL MEALS ACT 2006/

(Албан бус орчуулга)

## 1 дүгээр зүйл. Зорилго

Энэ хуулийн зорилго нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг дээшлүүлж, сурагчдын оюун санаа, бие бялдрын хөгжилд хувь нэмэр оруулах, сургуулийн хоолны үйлчилгээгээр дамжуулан үндэсний хоолны дэглэмийг сайжруулахад оршино.

## 2 дугаар зүйл. Нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1."Сургуулийн хоолны үйлчилгээ" гэж 1 дүгээр зүйлд заасан зорилгод хүрэхийн тулд сургуулийн захирал, сурагч, сурагчдад 4 дүгээр зүйлд заасан хоолны үйлчилгээ;

2. "Сургуулийн хоолны үйлчилгээ эрхлэгчид" гэж 15 дугаар зүйлийн дагуу сургуулийн захиралтай гэрээ байгуулсны дагуу сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч этгээдийг;

3. "хоолны үйлчилгээний зардал" гэж хоол хүнсний зардал, хоол хүнсний үйлчилгээний үйл ажиллагааны зардал, хоол хүнсний үйлчилгээний байгууламж, тоног төхөөрөмжийн бусад зардал зэргийг багтаасан байна.

## 3 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн хүлээх үүрэг

1. Төрийн болон орон нутгийн засаг захиргаа нь сайн чанарын хөнгөлөлттэй чанартай сургуулийн хоолоор хангахад захиргааны болон санхүүгийн дэмжлэг үзүүлж, хоол тэжээлийн сургалтаар дамжуулан сурагчдад зөв хооллолт, хоолны дэглэмийг зөв зохистой зохицуулах чадварыг эзэмшигүүлэхэд шаардлагатай бодлогыг боловсруулах, уламжлалт хооллолтын соёлыг хадгалах, хөгжүүлэхэд оршино.

2. Нийслэлийн хот, Нийслэлийн тусгай хот, муж болон өөртөө засах тусгай мужийн Боловсролын албаны дарга (цаашид "Боловсролын албаны дарга" гэх) - нь жил бүр сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлнэ.

## 4 дүгээр зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээнд хамрагдах оюутнууд ба сурагчид

Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу дараах дэд хэсгүүдэд заасан сургуулийн сурагчдад сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлнэ. Үүнд:

1. Бага, дунд боловсролын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1-4 дүгээр хэсэгт заасан сургууль;

2. Бага, дунд боловсролын тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу хөдөлмөр эрхэлж буй залуучуудад зориулсан тусгай ангиуд болон аж үйлдвэрийн байгууллагын дэргэдэх дунд сургууль, ахлах сургуулиуд;

3. Боловсролын албаны даргын хүлээн зөвшөөрсөн бусад сургуулиуд.

## 5 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний хороо

1. Боловсролын албаны дарга бүр дараах асуудлыг хэлэлцэх зорилгоор Сургуулийн хоолны үйлчилгээний хороог байгуулна:

1) 3 дугаар зүйлийн (2) дахь хэсэгт заасан сургуулийн хоолны үйлчилгээний төлөвлөгөө;

2) 9 дүгээр зүйлд заасан хоолны зардлыг татаас;

3) Боловсролын албаны даргын сургуулийн хоолны үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн бусад асуудлууд.

2. 1. дэх хэсгийн заалтад заасан Сургуулийн хоолны үйлчилгээний хорооны бүтэц, үйл ажиллагаа зэрэг холбогдох асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

3. Нийслэлийн хотын дарга, Нийслэлийн тусгай хотын дарга, муж болон өөртөө засах тусгай мужийн захирагч нь 8 дугаар зүйлийн (4) дэх хэсгийн заалтын дагуу сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих асуудлуудыг хэлэлцэхэд чиглэсэн сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороог байгуулж болно.

4. Өөртөө засах тусгай мужийн захирагч, эсхүл Хот, тойрог, автономит дүүргийн дарга нь сайн чанарын хоол хүнсний бүтээгдэхүүнээр хангах зэрэг сургуулийн хоол

хүнсний үйлчилгээг дэмжихийн зорилго бүхий Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийг байгуулж, ажиллуулж болно.

5. З дахь хэсэгт заасан сургуулийн хоолны үйлчилгээг дэмжих зөвлөлдөх хороо болон (4) хэсэгт Сургуулийн өдрийн хоолыг дэмжих төвийн бүтэц, бүрэлдэхүүн, байгуулах, үйл ажиллагаатай холбоотой асуудлыг холбогдох орон нутгийн засаг захирамжаар тогтооно.

## **6 дугаар зүйл. Хоолны үйлчилгээний барилга байгууламж, тоног төхөөрөмж**

1. Сургуулийн хоолны үйлчилгээг гүйцэтгэх сургуулиуд нь сургуулийн хоолны үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна. Хоёр сургуулиас доошгүй сургууль ойрхон байрлах байх тохиолдолд тэдгээр нь сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмж, байгууламжийг хамтран байгуулж, ашиглаж болно.

2. 1 дэх хэсэгт заасан байгууламж, тоног төхөөрөмж, тоног төхөөрөмжийн төрөл, шалгуур үзүүлэлтийг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

## **7 дугаар зүйл. Хоол зүй, шим тэжээлийн багш (Nutrition teachers)**

1. 6 дугаар зүйлд зааснаар сургуулийн хоолоор хангах тоног төхөөрөмжөөр тоноглогдсон сургуулиуд нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 21.2-т заасан хоол зүй, шим тэжээлийн багш, Хүнсний эрүүл ахуйн тухай хуулийн 53.1-т заасан мэргэжлийн тогоочийг ажиллуулна.

2. Боловсролын алба хариуцсан ахлах мэргэжилтэн нь сургуулийнхаа хоолны газрын үүрэгт онцгой үүрэг гүйцэтгэх сургуулийн хоолны үйлчилгээнд мэргэшсэн ажилтнуудыг өөрийн эрх мэдлийн хүрээнд байрлуулж болно.

## **8 дугаар зүйл. Сургуулийн хоолны зардал**

1. Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч төр, орон нутгийн захирамжаанаас татаас олгож болно.

2. Зарчмын хувьд, хоолны үйлчилгээний зардлыг тухайн сургуулийн үүсгэн байгуулагч, эрхлэгч хариуцах боловч Ерөнхийлөгчийн захирамжид заасан зарим зардлыг хамгаалагч хариуцна (эцэг, эх, асран хамгаалагч болон хуулиар эрх олгогдсон бусад хүмүүс)

3. Сургуулийн хоолны зардлыг зарчмын хувьд хамгаалагч хариуцна.

4. Тусгай хотын дарга, өргөтгөсөн хотын дарга, мужийн захирагч, өөртөө засах тусгай мужийн захирагч, болон хот, гүн, өөртөө засах дүүргийн дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах, үүнд хөдөө аж ахуйн сайн чанарын бүтээгдэхүүн хэрэглэх, хоолны үйлчилгээний барилга байгууламжийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг сайжруулах зэрэгт хоол хүнс, байгууламж, тоног төхөөрөмжийн зардлын татаас олгож болно.

## **9 дүгээр зүйл. Хоол хүнсний үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх**

1. 8 дугаар зүйлд заасан хамгаалагчийн хариуцах зардлыг төр, эсхүл орон нутгийн захирагаа бүрэн буюу хэсэгчлэн хариуцаж болно.

2. Хэрэв хамгаалагчийн хариуцах зардлыг 1-р хэсэгт зааснаар татаас олгох бол дараах сурагчдад, дор дурдсан төрлийн татаас олгоно:

- 1) Сурагч, эсхүл түүний хамгаалагч нь тусламж авах нөхцөлийг хангасан, эсхүл Үндэсний амьжиргааны суурь баталгааны тухай хуулийн 2 дугаар заасан ангилалд багтах, эсхүл Ганц бие эцэг, эхийг дэмжих тухай хуулийн 5-д заасны дагуу тусламж авдаг бол;
- 2) Арал болон алслагдсан бүс нутаг дахь боловсролыг дэмжих тухай хуулийн 2-р зүйлд заасны дагуу арал, эсхүл алслагдсан нутаг дахь сургуульд суралцагч, эсхүл Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон сургуулиудын сурагч;
- 3) Хөдөө аж ахуй, загас агнуурын тосгоныг дэмжих, хөдөө аж ахуй эрхлэгч, загасчдын амьдралын чанарыг сайжруулах тухай тусгай хуулийн 3.4-т заасан хөдөө аж ахуй, уулархаг, загас агнуурын тосгонд байрлах сургуульд сурч буй сурагчид, эсхүл Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон сургуулиудын сурагч;
- 4) Боловсролын албаны даргын хүлээн зөвшөөрсөн бусад сурагчид.

## **10 дугаар зүйл. Хүнсний бүтээгдэхүүн**

1. Сургуулийн хоолны үйлчилгээнд сайн чанарын, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэнэ.
2. Хүнсний бүтээгдэхүүнд тавигдах шалгуур болон хүнсний бүтээгдэхүүнтэй холбоотой бусад асуудлыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

## **11 дүгээр зүйл. Хоол тэжээлийн менежмент**

1. Сургуулийн хоолны үйлчилгээнд сурагчдын эрүүл мэнд, өсөлт хөгжилтэд шаардлагатай хоол тэжээлийг хангаж, хоолны зөв дадал зуршлыг бий болгоход туслах хоол хүнсийг хэрэглэнэ.
2. Сургуулийн хоолны шим тэжээлд тавигдах шалгуурыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

## **12 дугаар зүйл. Ариун цэвэр, эрүүл ахуйн менежмент**

1. Сургуулийн хоолны үйлчилгээг хоол хүнсэнд аюултай материалыг холихгүй байх, цэсийг төлөвлөх, худалдан авах, шалгах, хадгалах, угаах, хоол бэлтгэх болон хоол, хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх, борлуулах, түгээх, ариутгах зэрэг бүхий л шатанд эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах замаар зохион байгуулна.
2. Сургуулийн хоол хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдалд тавигдах шалгуурыг Боловсролын яамны тогтоолоор тогтооно.

## **13 дугаар зүйл. Хооллох дадал, зуршил**

Сургуулийн захирал нь сурагчдад зөв хооллолт, хоолны зөв дадал зуршил бий болгоход чиглүүлж, хоол, хүнсний үйлдвэрлэл, хэрэглээний талаарх мэдлэгийг дээшлүүлж, уламжлалт хоол хүнсний соёлыг залгамжуулж, хамгаалагчдыг холбогдох мэдээллээр хангана.

## **14 дүгээр зүйл. Шим тэжээлийн зөвлөгөө**

Сургуулийн захирал нь хооплолт, хоолны дадал зуршилаас үүссэн шим тэжээлийн өөрчлөлтийг бууруулах мөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс бага жинтэй, өсөлтийн хоцрогдол, цус багадалт, илүүдэл жин, таргалалт зэрэг хоол тэжээлийн зөвлөгөө шаардлагатай сурагчдад заавар, зөвлөгөөгөөр хангаж ажиллана.

## **15 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааны зохион байгуулалт**

1. Сургуулийн захирал нь сургуулийн хоолны үйлчилгээг шууд удирдан зохион байгуулах бөгөөд Бага, дунд боловсролын тухай хуулийн 31-д заасан Сургуулийн үйл ажиллагааны хороотой хэлэлцсэний үндсэн дээр сургуулийн хоолны үйлчилгээг тодорхой шаардлагыг хангасан хүнд хариуцуулж болно. Тухайн хүнд сургуулийн хоолны үйлчилгээний нөхцөл байдлын зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд хоол, хүнсний бүтээгдэхүүн сонгох, худалдан авах, хянан шалгах үүргийг шилжүүлэхгүй.

2. Ерөнхий боловсролын байгууллага нь 1 дэх хэсэгт заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авна.

3. 1 дэх хэсэгт заасан сургалтын хоолны үйлчилгээг шилжүүлэхтэй холбоотой сургуулийн хоол, хүнс бэлтгэн нийлүүлэгчдэд тавигдах шаардлага болон дээрх эрхийг шилжүүлэхтэй холбоотой бусад асуудлыг Ерөнхийлөгчийн захиралмжаар тогтооно.

## **16 дугаар зүйл. Чанар, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудал**

1. Сургуулийн захирал болон сургуулийн хоолны үйлчилгээтэй хариуцсан сургуулийн ажилтан (цаашид "сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан" гэх) болон сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь дор дурдсан хүнсний бүтээгдэхүүнийг хүнсний чанар болон аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэглэхгүй:

- 1) Хөдөө аж ахуй, загас агнуурын бүтээгдэхүүний гарал үүслийн тухай хуулийн 5.1-т заасан гарал үүслийн тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;
- 2) Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хуулийн 56-р зүйлд заасан генийн өөрчлөлттэй хөдөө аж ахуйн болон загас агнуурын бүтээгдэхүүний тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;

- 3) Мал аж ахуйн тухай хуулийн 40-р зүйлд заасан мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ангиллыг тэмдэглэгээний зөрчилтэй хоол, хүнс;
  - 4) Зүйл 14.3-р зүйлд заасан чанарын гэрчилгээ, эсхүл газар зүйн заалтад заасан чанарын баталгаажуулалтыг Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн (2) дахь стандартын бүтээгдэхүүний стандартыг заана. 34 (3) дугаар зүйл.
2. Сургуулийн захирал, сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан болон сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч нь дараахыг дагаж мөрднө:
- 1) 10.2-т заасан хүнсний бүтээгдэхүүний чанарын хяналтын шалгуур, 11.2-т заасан хоол тэжээлийн менежментийн шалгуур, 12.2-т заасан эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналтын шалгуур үзүүлэлт;
  - 2) Боловсролын яамны тогтоолоор баталсан сургуулийн хоол хүнсний чанар, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай бусад зүйлс.
3. Сургуулийн хоол нь харшил үүсгэгч/өдөөгч хоол хүнсний бүтээгдэхүүн агуулсан бол, сургуулийн захирал, сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой сургуулийн ажилтан сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч нь тус хоол, хүнсний талаар сурагчдад мэдэгдэж, сургуулийн хоолоор үйлчлэхдээ харшил үүсгэгчтэй болохыг тэмдэглэнэ.
4. 3-р хэсэгт заасан харшил үүсгэгчтэй хүнсний талаар мэдээлэх, тэмдэглэгээ хийхтэй холбоотой асуудлыг Боловсролын яамны тогтоолоор шийдвэрлэнэ.

### **17 дугаар зүйл. Үйлдвэрлэсэн хоол, хүнсний шууд хэрэглээ**

Сургууль дээр хоол, хүнсний бүтээгдэхүүнийг тариалах, мал өсгөх болон бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас олж авсан хоол, хүнсний бүтээгдэхүүн, эсхүл тэдгээрийн борлуулснаас олсон бусад хуульд заасныг үл харгалзан сургуулийн хоолны үйлчилгээнд шууд ашиглаж болно.

### **18 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээний үнэлгээ**

1. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга нь сургуулийн хоолны үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сургуулийн хоолны үйл ажиллагааны үнэлгээ хийж болно.
2. 1 дэх хэсгийн үнэлгээний арга, шалгуур болон сургуулийн хоолны үйлчилгээний үйл ажиллагааг үнэлэхэд шаардлагатай бусад асуудлыг Ерөнхийлөгчийн захирамжаар тогтооно.

### **19 дүгээр зүйл. Нэвтрэх, үзлэг хийх, хурааж авах**

1. Боловсролын сайд, эсхүл Боловсрол албаны дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хоолны эрүүл ахуй, эсхүл хоолны үйлчилгээ хариуцсан төрийн албан хаагчдад сургуулийн хоолны үйлчилгээнд хамаарах барилга байгууламжид нэвтэрч, хоол, хүнс, барилга байгууламж, бичиг баримт, үйл ажиллагааны нөхцөл байдалд үзлэг, шалгалт хийх, эсхүл хоол, хүнсний шинжилгээнд хамруулахад шаардагдах хамгийн бага хэмжээтэй хоол хүнсийг нөхөн олговоргүй хураан авах эрх олгож/дээж авах/ шаардаж болно.

2. 1 дэх хэсэгт заасны дагуу нэвтрэх, хянан шалгах, дээж авах үйл ажиллагаа явуулах гэж буй төрийн албан тушаалтан нь өөрийн бүрэн эрхийг гэрчилсэн үнэмлэхийг биедээ авч явж, холбогдох хүмүүст үзүүлнэ.

3. Хяналт шалгалтаар 16.1.1-2 дахь хэсэг болон 16.3-т заасныг зөрчсөнийг илрүүлсэн тохиолдолд Боловсролын сайд, Боловсролын албаны дарга нь илрүүлсэн зөрчлийг зогсоох, арилгуулах шаардлагыг сургуулийн захирал сургуулийн хоолны нийлүүлэгчид хүргүүлж болно.

### **20 дугаар зүйл. Эрх шилжүүлэх**

Энэхүү хуульд заасан Боловсролын сайд, Боловсролын албаны даргын эрхийг хэсэгчлэн Ерөнхийлөгчийн захирамжаар тогтоосон журмын дагуу Боловсролын албаны дарга, эсхүл дүүргийн боловсролын албаны даргад шилжүүлж болно.

### **21 дүгээр зүйл. Захиргааны арга хэмжээ**

1. 19-р зүйлд заасан хяналт шалгалтын дунд Хоол хүнсний эрүүл ахуйн тухай хууль, Хөдөө аж ахуй, загасны аж ахуйн бүтээгдэхүүний чанарын хяналтын тухай хууль, Мал аж

ахуйн тухай хууль, Мал аж ахуйн бүтээгдэхүүний эрүүл ахуйн хяналтын тухай хуульд заасан зөвшөөрөл авсан, томилогдсон буюу баталсан этгээд холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон бол Боловсролын сайд, эсхүл Боловсролын албаны дарга нь холбогдох захиргааны байгууллагад захиргааны арга хэмжээ зэрэг шаардлагатай арга хэмжээ авахыг хүсэлт гаргаж болно.

2. 1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллагын дарга нь тусгай шалтгаанаас бусад тохиолдолд дээрх хүсэлтийг биелүүлэх бөгөөд Боловсролын сайд, эсхүл холбогдох Боловсролын албаны даргад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдэгдэнэ.

## **22 дугаар зүйл. Сахилгын арга хэмжээ**

Сахилгын шийтгэл ногдуулах санал гаргах эрхтэй этгээд нь холбогдох сахилгын хэргийг хамаарах сахилгын хороонд сургуулийн хоолны үйлчилгээний зохих ёсны үйл ажиллагаа явуулах, аюулгүй байдлыг хангуулах зорилгоор өөрийн харьяа сургуулийн захирал, болон дараах ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах хүсэлтийг гаргана:

- 1) Хоол хүнсний хордлого зэрэг эрүүл ахуй, аюулгүй байдалд санаатай, эсхүл санамсаргүй байдлаар осол/зөрчил гаргасан хүнд;
- 2) Сургуулийн хоолны үйлчилгээний гэрээг цуцлах үндэслэл бий болсон хэдий ч гэрээг цуцлаагүй хүнд;
- 3) 19.3-т заасны дагуу Боловсролын сайд, эсхүл Боловсролын албаны даргын зөрчлийг арилгуулахаар гаргасан шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй хүнд;
- 4) Сургуулийн хоолны үйлчилгээтэй холбоотой авлигын хэрэгт холбогдсон хүнд.

## **23 дугаар зүйл. Шийтгэл ногдуулах**

1. 16-р зүйлийн 1.1, 1.2 дахь хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 7 жилээс дээшгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 100 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

2. 16-р зүйлийн 1.3 дахь хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчийг 5 жилээс дээшгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 50 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

3. Дараах этгээдийг гурван жилээс илүүгүй хугацаагаар хорих (imprisonment with labor), эсхүл 30 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

- 1) 16-р зүйлийн 1.4 дэх хэсгийг зөрчсөн сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгч;
- 2) 19-р зүйлийн 1 дэх хэсэгт заасны нэвтрэх, хянан шалгах, дээж авах, хураан авах ажиллагаанд үндэслэлгүйгээр татгалзсан, саад учруулсан, эсхүл зайлсхийсэн этгээд.

## **24 дүгээр зүйл. Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх**

Компанийн төлөөлөгч, ажилтан, эсхүл хувь хүний аливаа ажилтан нь компани буюу хувь хүний үйл ажиллагаатай холбоотойгоор 23 дугаар зүйлд заасан зөрчлийг гаргасан бол зохих зөрчилд оногдуулах шийтгэлээс гадна, компаний, эсхүл хувь хүнд холбогдох зөрчилд тохирох торгох шийтгэлийг оногдуулна. Дээрх нь компани, эсхүл хувь хүн дээр дурдсан зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих зэрэгт хайхрамжгүй хандаагүй тохиолдолд үйлчлэхгүй.

## **25 дугаар зүйл. Торгууль**

1. 16.2-р зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчилд 19.3-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид 5 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

2. 16.2-р зүйлийн 2 дахь хэсэг, 16.3-р зүйлд заасан зөрчилд 19.3-р зүйлд заасан зөрчлийг арилгуулах шийдвэрийг үндэслэлгүйгээр биелүүлээгүй сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлэгчид 3 сая воноос дээшгүй хэмжээний торгууль оногдуулна.

3. 1, 2 дахь хэсэгт заасан захиргааны шийтгэлийг Боловсролын сайд, Боловсролын албаны дарга Ерөнхийлөгчийн захирамжид заасны дагуу ногдуулж, хурааж авна.

## **БНХАУ<sup>270</sup>**

Бүгд Найрамдах Хятад Ард Улс сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хуульгүй бөгөөд Хятад Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хууль (*China's Food Safety Law, 2015*) болон зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан хөтөлбөрүүдээр зохицуулж байна. Сургуулийн хоолны системийн түгээлт, нийлүүлэлт, үйлдвэрлэлтийн талаар албан ёсны нэгдсэн бодлого одоогоор байхгүй. Тус улсад Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн нэгдсэн төсөв болон дэмжих бодлого одоохондоо байхгүйгээс сургуулийн хооллолтын систем нь сургууль, хот, хотын захиргаа, аймгуудын хүрээнд бие даасан байдалтай явагддаг байна.

### **Сургуулийн хооллолтын үйлчилгээ:**

Тус улсад сургуулийн хоолны үйлчилгээг 1980 оны эхэн үеэс “сургуулийн өдрийн хоолны хөтөлбөр” хэлбэрээр далайн эргийн хэдэн том хотуудад эхэлсэн. Мөн 1988 онд “Хятадын сурагч, оюутнуудын хоол тэжээлийг дэмжих холбоо” /Chinese Students Nutrition Promoting Association/ гэх бие даасан байгууллагыг сургуулийн хүүхдийн хоолны хөтөлбөрийг өргөжүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулахад бүх оролцогчдыг /хувийн болон улсын/ нэгтгэх зорилгоор байгуулсан. Улмаар 2000 оны эхээр “БНХАУ-ын Сургуулийн Сүүний Хөтөлбөр” (China School Milk Programme) дөрвөн хотод хэрэгжиж эхэлсэн байна.

Засгийн газраас Сургуулийн сүүний хөтөлбөрт дэмжлэг үзүүлээгүй ч хэлэлцээрээр нөхөн төлөгдөх зах зээлийн үнээс 25-30 хувиар хямдралтай үнээр сүүг хотын сургуулийн хүүхдүүдэд өгөх болсон нь улсын эдийн засаг болон сүүний үйлдвэрлэлд хувь нэмэр оруулахын зэрэгцээ сурагчдын хоол тэжээлийг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой байсан байна.

Сургуулийн сүүний хөтөлбөрийн эхний туршилтын үед 223 ажлын байр шинээр бий болж, 100,000 гаруй сурагчийг сүү хөтөлбөрт хамруулсан байна. 2007 онд Сургуулийн сүү хөтөлбөрт Тэтра Пак савлагааг нэвтрүүлж, сурагчдад 5,3 тэрбум сав сүүгээр хангасан байна.

Сургуулийн өдрийн хоолны хөтөлбөр нь ихэнхдээ хотын бүсэд байрладаг сургуулиудад хэрэгждэг бол хөдөөгийн алслагдмал бүсэд амьдардаг сурагчдын дунд хоол тэжээлийн дутагдал хамгийн түгээмэл байдаг байна.

Мөн сурагчдын үдийн хоолыг маш шим тэжээлтэй мэтээр ойлголт өгч мэдээлэх хэдий ч ихэнх үдийн хоол нийлүүлэгчид сурагчдын амтанд тааруулж шим тэжээлийг бага анхаардаг ажээ. Дээрх шалтгаануудаас үүдэн 2005 онд хүлээн зөвшөөрөгдсөн сургуулийн үдийн хоолны сүлжээ том хотуудын сургуулиудын 30-50% болон дунд, жижиг хотын сургуулиудын 18-35%-ыг хамарсан. Хөдөөгийн бүсийн сургуулиудад, ялангуяа Хятадын баруун хэсгийн ядуу бүсийн сургуулиудад сургуулийн хоолны хөтөлбөр одоог хүртэл байдаггүй байна.

Хятадын Засгийн газраас сургуулийн хоолны хөтөлбөрүүдийг төдийлөн санхүүжүүлдэггүй ч сүүлийн жилүүдэд хөдөөгийн бүсийн захиргаад бага сургуулийн сурагч бүрт 500 юань/73 ам.доллар болон дунд сургуулийн сурагч бүрт 750 юань/110 ам.долларыг сурагчдын хоолны шим тэжээлийг сайжруулахын тулд санхүүжүүлэхээр болжээ.

Вьетнамын хилийн дагуу Өмнөд Хятадад байрладаг *GuangXi* өөртөө засах бүсэд Хятадын хөгжлийн судалгааны сангаас жил бүр нэг сурагчид дунджаар 1000 юаны санхүүжилт бүх сургуулийн үдийн хоолны туршилтын хөтөлбөрийг явуулж эхэлсэн ба нэг өдрийн хоол 2,5-5 юаний үнэтэй байна.

### **Бодлогын зохицуулалт:**

Сургуулийн хоолны тогтолцооны тараалт, нийлүүлэлт, үйлдвэрлэлтийн талаар албан ёсны нэгдсэн бодлого одоогоор Хятадад байхгүй. Мөн Үндэсний сургуулийн хоолны

<sup>270</sup> [https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012\\_scs](https://apec.org/-/.../APEC/.../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs)

хөтөлбөрийг санхүүжүүлэх болон дэмжих бодлого байхгүйн улмаас сургуулийн хоолны хөтөлбөрүүд нь сургууль, хот, аймгуудын хүрээнд бие даасан байдалтай явагдаж байна. Үүнээс улбаалан хөтөлбөрийн чанар, зардал, сурагчдыг хамрах байдлын хувьд ихээхэн ялгаатай байна.

Эцэг, эхчүүд хоолны төлбөрийг төлөх, эсхүл хоолны зардлыг бууруулахад будаа зэрэг хүнсээр хангаж оролцдог. Ядуу өрхийн сургуулийн сурагчдад үнэгүй, эсхүл хөнгөлөлттэй хоолоор хангах тогтолцоо бүрдээгүйн улмаас маш олон хүүхэд сургууль дээрээ хоолгүй, эсхүл бүтэн порц хоол худалдаж авах боломж бага байдаг байна. Цөөн тооны том хотуудад ядуу өрхүүдэд Нийгмийн халамжийн газраас сургуулийн хоолны дэмжлэг үзүүлдэг байна.

Хятадын Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 57 дугаар зүйлд зааснаар “Сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, сувиллын хоол үйлдвэрлэлийн газрууд нь хууль тогтоомж, дүрэм журам, хүнсний аюулгүй байдлын стандартыг бүрэн дагаж мөрдөнө. Хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд аливаа байгууллага, хувь хүн хүнсний үйлдвэрлэл, хуваарилалтын лицензтэй байхыг шаардана. Хоолны үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомж, дүрэм журам, хүнсний аюулгүй байдлын стандартыг дагаж мөрдөн, энэхүү хуульд заасан журмын дагуу хоол боловсруулж, хүнсний аюулгүй байдлыг хангана” гэж заажээ.

Мөн хуульд тусгаснаар “Сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, сувиллын хоолны газраар үйлчлүүлэх эрх бүхий байгууллага, этгээд нь хүнсний баталгаат байдлыг хангахын тулд хүнсний аюулгүй байдлын талаарх боловсрол, өдөр тутмын менежментийг нэгтгэснээр хүнсний аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг бууруулна” гэжээ.

#### **Хүнс худалдан авах ажиллагаа: /Сычуань мужийн жишээ/**

Орон нутгийн нөөц боломжоор сургуулийн шим тэжээллэг хоолны хөтөлбөрүүдийг дэмжих боломжтой юм. Зорилтот сургуулиудад хэрэгжиж буй сургуулийн хоолплотын загвар хөтөлбөрүүд нь сургуулийн хоолны хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлэх үндэс суурь болж болох боловч хөтөлбөрийг хөгжүүлэх, өргөжүүлэхэд Засгийн газрын дэмжлэг дутмаг байна.

Deyang сургууль (Сычуант мужид байрлалтай) нь жимс, ногоо, загас, мах зэргийг хүнсний захуудаас худалдан авдаг бол түргэн мууддаггүй хүнсний бүтээгдэхүүн болох гурил, будаа, ургамлын тос зэргийг Хүнсний хяналтын байгууллага /DEB/-аас чанарын шаардлага хангасан, итгэмжлэгдсэн нийлүүлэгчдээс худалдан авахыг шаардлага болгодог байна. Бүх сургуулиудад худалдан авахтай холбоотой ажиллагааг (бэлтгэн нийлүүлэгчийн мэдээлэл) баримтжуулахыг шаарддаг. Ялангуяа худалдан авах эх үүсвэр болон нийлүүлэгчийг хянахыг шаарддаг. Мөн түүнчлэн, сургуулиудад 24-48 цагийн турш бүх хоолноос дээж авахыг шаарддаг байна. Хэрвээ ямар нэг хоолтой холбоотой асуудал гарвал эдгээр дээжүүдээс асуудлыг тодруулах шинжилгээ хийгддэг. DEB нь чанаж болгоогүй хоол хүнс вирусыг илүү хялбар тархаадаг учир сургуулиудад хүйтэн хоолоор үйлчлэхгүй байхыг зөвлөдөг.

Хэдийгээр сургууль нь орон нутгийн үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнийг ашигладаг боловч фермерүүд нь фермийг хөнгөвчлөхийн тулд хоршоо, эсхүл бусад маркетингийн бүлгүүдэд зохион байгуулагддаггүй байна. Үр тариа, мах, шувуу зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг сургуулиудад сонгон шалгаруулалтаар сонгогдсон тухай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий бэлтгэн нийлүүлэгчид орон нутгийн эрүүл мэндийн хэлтэс хянан, Ихэвчлэн 2-3 тендер зах зээлийн үнээс 10%-иар бага байдаг. Жимсийг орон нутгийн фермерүүдээс худалдаж авахаас гадна хүнсний ногоог ихэнхдээ шинэ хүнсний захаас худалдаж авдаг байна.

Хятад Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 125 дугаар зүйлд зааснаар “Төвлөрсөн хоолны газар (кафетери)-тай сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, барилга байгууламж нь хүнсний аюулгүй байдлыг хангах хариуцлагагаа биелүүлээгүй, хүнсний үйлдвэрлэгчид болон хоолны үйлчилгээ үзүүлэгчид нь үйлдвэрлэлийн болон түгээлтийн үйл явцад хяналт тавих үйл ажиллагааг зохицуулж чадаагүй зэрэг тохиолдолд тухайлбал, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч буюу түгээгч нь хууль бусаар үйлдвэрлэсэн,

худалдаалагдсан хүнсний болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, түүнчлэн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүнсний түүхий эд, мужийн тувшний ба түүнээс дээш тувшний Засгийн газруудын хүнсний болон бусад хууль бус үйлдвэрлэл, түгээлтийг ашигласан бол бараа бүтээгдэхүүний нийт үнэ 10,000 юань буюу түүнээс бага бол 5,000-50,000 юаньтай тэнцэх, 10,000 юанаас дээш тохиолдолд барааны нийт үнийг 5-10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ногдуулах, мөн ноцтой зөрчил гаргасан тохиолдолд үйлдвэрлэлийн буюу аж ахуйн үйл ажиллагааны лицензийг хүчингүй болгох шийтгэлийг тус тус ногдуулдаг байна.

## **ОХУ**

ОХУ-д сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг зохицуулсан бие даасан хууль, сургуулийн үдийн цайны үндэсний хөтөлбөр байхгүй бөгөөд тухайн асуудлыг “ОХУ-ын боловсролын тухай хууль”<sup>271</sup> болон зарим бодлогын баримт бичгийн хүрээнд боловсруулагдсан томоохон бус нутгуудын хөтөлбөрүүд, эрүүл ахуйн шаардлагуудаар зохицуулж байна. ОХУ-ын хувьд сүүлийн жилүүдэд сургуулиудад хоолны хордлогуудын тохиолдууд ихэссэн зэрэг хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл ахуйтай холбоотойгоор сургуулийн хоолны эрх зүйн орчныг сайжруулах асуудлаар холбооны болон субъектуудын удирдлагууд тодорхой алхмууд авч эхлээд байгаа. Тухайлбал, (ОХУ-ын сургуулийн хоолны үйлдвэрлэлийн тогтолцоо, оролцогч талуудыг Зураг 4-с үзнэ үү.)

Холбооны хэмжээний боловсролын салбарын хууль тогтоомжуудад сургууль, цэцэрлэгийн сурагчдын хоолны үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоотой асуудлыг ерөнхий хүрээнд зохицуулсан байх бөгөөд тодорхой эрх, үүрэг, нөхцөлүүдийг тусгаагүй байна. Сургуулиудын хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг боловсролын байгууллага хариуцна. Хуульд заасны дагуу сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний эрх зүйн норм, нормативуудыг ОХУ-ын субъектуудын төрийн эрх барих байгууллага болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд тогтооно. Мөн дээрх байгууллагууд нь хоолны үнэ өртөг, санхүүжилтийн эх үүсвэр болон холбогдох дүрэм, журам, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах сурагчдын ангиллыг тогтоох болон бусад зохион байгуулалтын асуудлыг хариуцна.

**ОХУ-ын боловсролын тухай хууль (2012)-ийн 4 дүгээр бүлгийн 37 дугаар зүйлд:**

1. “Сурагчдын хоолны зохион байгуулалтын асуудлыг боловсролын байгууллага хариуцна.
2. Хичээлийн хуваарийг сурагчид хооллож хүрэлцэхүйц хугацааны завсарлагатай байхаар зохион байгуулна.
3. Батлан хамгаалах, аюулгүй байдлын салбар, ОХУ-ын Үндэсний харуулын цэрэг, далайн хөлөг онгоц, дотоодын усан хөлөг онгоц, загас агнуурын хөлөг онгоцын бие бүрэлдэхүүн бэлтгэх, нисэх онгоц, нисэхийн ажилтан, нислэгийн хөдөлгөөний удирдлагын ажилтан бэлтгэхэд чиглэсэн холбооны улсын боловсролын байгууллагын сурагч болон насанд хүрээгүй хүүхдийг цэргийн болон төрийн бусад албанд бэлтгэхэд чиглэсэн нэмэлт боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн болон ерөнхий боловсролын байгууллагуудын сурагчдын өдрийн хоолыг холбогдох холбооны улсын боловсролын байгууллагын үүсгэн байгуулагчаас тогтоосон нөхцөл, журамд заасан норм, стандартын дагуу зохион байгуулна.
4. ОХУ-ын субъектийн төсвөөр санхүүждэг сургуулийн сурагчдын өдрийн хоолыг ОХУ-ын субъектийн төрийн эрх барих байгууллагаас тогтоосон журам, нөхцөлийн дагуу, орон нутгийн төсвөөс санхүүждэг сургуулийн сурагчдын өдрийн хоолны зардлын орон нутгийн удирдлагын байгууллагаас тус тус санхүүжүүлнэ.” гэж заажээ.

Мөн хуулийн 28.7-д<sup>272</sup> Боловсролын байгууллага нь сурагч болон боловсролын

<sup>271</sup> Закон об Образовании в РФ, 2012 <http://zakon-ob-obrazovanii.ru>

<sup>272</sup> Образовательная организация несет ответственность в установленном законодательством Российской Федерации порядке за невыполнение или ненадлежащее выполнение функций, отнесенных к ее компетенции, за реализацию не в полном объеме образовательных программ в соответствии с учебным планом, качество образования своих выпускников, а также за жизнь и здоровье обучающихся, работников

байгууллагын ажилтны амь, нас эрүүл мэндэд хариуцлага хүлээхээр заасан байна. Хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, зөрчсөн боловсролын байгууллага болон түүний удирдлага нь ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээнэ. Ийнхүү сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг гэрээт байгууллага хэрэгжүүлсэн ч тухайн сургууль болон удирдлагууд нь сурагчдыг хоолны зохион байгуулалтад хариуцлага хүлээнэ.

Холбооны гүйцэтгэх засаглалын эрүүл мэнд, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүн амын эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналттай холбоотой хууль тогтоомжийг<sup>273</sup> судалж үзэхэд сурагчдын хоолны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг гол төлөв эрүүл ахуй, халдварт хамгааллын дадлын дүрмүүдээр зохицуулсан байна.

Сургуулийн хоолны эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын асуудлаар Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн хамгааллын албаны дарга – ОХУ-ын Улсын эрүүл ахуйн ерөнхий эмчийн тогтоолоор холбогдох норм, дүрмүүд<sup>274</sup>, Ерөнхий боловсролын бага, бүрэн дунд боловсролын сургуулийн сурагчдын хооллолтыг зохион байгуулахад тавигдах эрүүл ахуй, халдварт хамгааллын шаардлагыг<sup>275</sup> баталсан байна.

Түүнчлэн, эрүүл ахуй, халдварт хамгааллын дадлын дүрмийн хүрээнд сурагчдын хоолны зохион байгуулалтад дараах шаардлагуудыг баримтлахаар заасан байна.

1. Нийтийн хоолны үйлдвэрлэл, тэдгээрийн түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэх, эргэлтэд оруулах (худалдах, худалдан авах)-ад тавигдах ерөнхий эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын шаардлагууд.<sup>276</sup>
2. Түргэн муудах хүнсний бүтээгдэхүүний хадгалах хугацаа, хадгалах нөхцөлд тавигдах эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын шаардлагууд.

Сургуулийн хоолны үйлчилгээ, үйлдвэрлэлд тавигдах шаардлага, хүүхдийн хоолны хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, боловсруулалт болон дахин боловсруулах нь техникийн шаардлагуудаар зохицуулагдаж байна.

Нийтийн хоол үйлдвэрлэлийн ерөнхий зохион байгуулалтыг “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ОХУ-ын Засгийн газрын тогтоолоор батлагдсан Хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад тавигдах нийтлэг шаардлагаар

---

образовательной организации. За нарушение или незаконное ограничение права на образование и предусмотренных законодательством об образовании прав и свобод обучающихся, родителей (законных представителей) несовершеннолетних обучающихся, нарушение требований к организации и осуществлению образовательной деятельности образовательная организация и ее должностные лица несут административную ответственность в соответствии с Кодексом Российской Федерации об административных правонарушениях.

<sup>273</sup> Федеральный закон «О санитарно-эпидемиологическом благополучии населения» от 03.03.1999 г. № 52-ФЗ;

- Федеральный закон «О защите прав потребителей» от 07.02.1992 г. № 2300-1-ФЗ;  
- Федеральный закон «О качестве и безопасности пищевых продуктов» от 02.01.2000 г. № 29-ФЗ;  
- Федеральный закон «О техническом регулировании» от 27.12.2000 г. № 184-ФЗ;  
- Технические регламенты Таможенного союза на пищевые продукты;  
- СанПиН 2.3.2.1940-05 «Организация детского питания»;  
- СанПиН 2.3.2.1078-01 «Гигиенические требования к безопасности и пищевой ценности пищевых продуктов»;  
- СП 1.1.1058-01 «Организация и проведение производственного контроля за соблюдением санитарных правил и выполнением санитарно-противоэпидемических (профилактических) мероприятий»;  
- СП 2.3.6.1079-01 «Санитарно-эпидемиологические требования к организациям общественного питания, изготовлению и оборотоспособности в них продовольственного сырья и пищевых продуктов»;  
- МР 2.4.5.0107-15 «Организация питания детей дошкольного и школьного возраста в организованных коллективах»;

<sup>274</sup> “О введении в действие санитарно – эпидемиологических правил и нормативов СанПиН 2.4.2.1178-02”, СанПиН 2.4.5.2409-08;

<sup>275</sup> “Санитарно-эпидемиологические требования к организации питания обучающихся в общеобразовательных учреждениях, учреждениях начального и среднего профессионального образования” (от 23 июля 2008 г. № 45);

<sup>276</sup> “О введении в действие санитарных правил” (вместе с Санитарно-эпидемиологическими правилами “Санитарно-эпидемиологические требования к организациям общественного питания, изготовлению и оборотоспособности в них пищевых продуктов и продовольственного сырья”).

зохицуулж байна.


Дээрх шаардлагууд нь хэрэглэгч болон нийтийн хоолны үйлдвэрлэгч/үйлчилгээ үзүүлэгч хоёрын хоорондын харилцаа, хэрэглэгчдэд шаардлага хангасан, эрүүл мэнд, амь насанд аюулгүй үйлчилгээ авах, үзүүлж буй үйлчилгээ болон үйлчилгээ үзүүлэгч/нийлүүлэгчдийн талаарх мэдээ, мэдээллийг авах зэрэгтэй холбоотой эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг журамласан байна. Дээрх шаардлага, дүрмүүд нь нийтийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцогч бүхий л хэлбэр бүхий субъектуудад хамаарна. Дээрх дүрмүүдэд нийтийн хоол үйлдвэрлэгч болон хэрэглэгч хоёрын хоорондын харилцаа гэрээний үндсэн дээр явагдахыг заасан байна.

Нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх ерөнхий дүрэмд боловсролын байгууллагатай холбоотой тусгай заалт, хязгаарлалт тусгаагүй байна.

ОХУ-ын орчин үеийн практикт ерөнхий боловсролын сургуулиудад дараах хоёр хэлбэрээр сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг үзүүлж байна. Эхний тохиолдолд гуравдагч этгээд (гэрээт нийлүүлэгч) сургуулийн хоолны газарт хоол, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж, сургуулийн хоолны газар нь өөрийн гал тогоондоо хоолоо бэлтгэх. Нөгөө хувилбар нь гуравдагч этгээд (гэрээт нийлүүлэгч) нь хоолны үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой бүхий л асуудлыг хариуцах байна.

Дээрхээс үзэхэд сургууль, цэцэрлэгийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээг сургуулийн хоол хүнсний комбинат, боловсролын байгууллагын цайны газар, буфет болон нийтийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн компаниуд гүйцэтгэж байна. Хоол хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч нь боловсролын байгууллагатай гэрээ байгуулахдаа хоол, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалалтын горим, тээвэрлэлт зэргийг хариуцдаг бол сурагчдын хоолыг сургууль дээр бэлтгэх тохиолдолд хоол, хүнс хадгалалтын горим, үйлдвэрлэлийн технологийг сургуулийн удирдлага хариуцдаг байна. Гуравдагч этгээд бэлэн бүтээгдэхүүнээр хангах тохиолдолд бүтээгдэхүүний чанар, үйлдвэрлэлийн технологи, хангамж зэрэг асуудлыг нийлүүлэгч хариуцах хэдий ч гэрээ байгуулсан сургууль нь мөн адил хариуцлага хүлээнэ. Сургуулийн эрүүл мэндийн ажилтнууд нь бүтээгдэхүүний чанар болон боловсруулалтад хяналт тавьж ажиллана.

#### **Зураг 4. ОХУ-ЫН Сургуулийн хоолны үйлдвэрлэлийн тогтолцоо, оролцогч талууд**



Эх сурвалж: School Feeding in APEC Economies, APEC Subcommittee on Standards and Conformance, 2012

## **СЛОВЕНИ**

Словени Улс нь Сургуулийн хоол тэжээлийн тухай анхны хуулийг 1953 онд баталсан бөгөөд тухайн цагаас хойш бага, дунд сургуулийн бүх сурагчдыг хоол хүнсээр хангаж, хүүхдийн эрүүл мэндэд хөрөнгө оруулалт хийж ирсэн байна. Дэлхийн хоёрдугаар дайны дараагаар Словенийн бүх бага сургуулиуд нь сургуулийн гал тогоо, хоолны танхимтай болсон байна.

2010 онд батлагдсан Словенийн Сургуулийн хоолны тухай хуульд 2013 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан, мөн хуульд тусгагдсан Цэцэрлэгийн эрүүл хоол тэжээлийн Үндэсний Хоолны удирдамж (2005) нь Үндэсний сургуулийн хоолны хөтөлбөрийн стандартыг тогтоож өгсөн ба тус хөтөлбөрийн хүрээнд сургуулийн бүх сурагчдыг өдөр бүр хоол тэжээлийн тэнцвэртэй хоолоор хангах ёстой. Сургуулийн хоол нь гол төлөв үдийн цай, эсхүл хоол байх ба илчлэг, шим тэжээлийн агууламжид тавигдах шаардлага болон хэрэглэвэл зохих болон хэрэглэхээс татгалзвал зохих хоол, хүнсний жагсаалтад нийцсэн байна.

Сургууль, цэцэрлэг болон бусад байгууллагууд хоол бэлтгэхдээ Ерөнхий боловсролын үндэсний зөвлөлийн экспертуудээс боловсруулан гаргасан мэргэжлийн удирдамжийг даган мөрдөнө. 2010 онд батлагдсан Словенийн Сургуулийн хоолны тухай хуулиар сургуулийн орчинд хоол, хүнсний автомат машин байрлуулахыг хориглосон ба үйлдвэрлэгч, нийлүүлэгчид тус заалтыг эсэргүүцэн Үндсэн хуулийн шүүхэд маргаан үүсгэсэн ч шүүх хориглосон заалтыг хэвээр үлдээсэн байна.

## **СУРГУУЛИЙН ХООЛНЫ ТУХАЙ ХУУЛЬ /SCHOOL MEALS ACT 2012/<sup>277</sup>**

(Албан бус орчуулга)

### **Нийтлэг үндэслэл**

#### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилго**

Энэхүү хуулийн зорилго нь сурагчдын сургуулийн хоолыг зохион байгуулах, сурагчдын хөнгөлөлттэй хоолоор хангах эрх, сургуулийн хоолонд олгох хөнгөлөлт, татаасын хэмжээ, нөхцөлийг тодорхойлох, хуулийн хэрэгжилтийг хянахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

1. Энэхүү хууль нь бага, дунд сургууль болон тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд, залуучуудад бүх нийтийн боловсрол олгодог сургуулиудыг хамарна.
2. Энэхүү хууль нь насанд хүрэгчдийн боловсролын хөтөлбөрт хамрагсдад үйлчлэхгүй.
3. Тус хуулийн 4.6, 4.8-р заалт, 19-20-р зүйл нь цэцэрлэгт хамаарна.

#### **3 дугаар зүйл. Хуулийн зорилт**

Энэхүү хуулийн зорилт нь:

- Тогтвортой хэрэглээний зарчмыг харгалзан, сургуулийн хоолны шим тэжээлийн чанарыг хангах замаар сурагчдын хөгжлийг дэмжих, эрүүл зөв хооллолт болон хоолны соёлын талаарх ойлголтыг дээшлүүлж, өөрийн үүрэг хариуцлага (өөрийн эрүүл мэнд болон байгаль орчинд хариуцлагатай хандах)-ыг ухамсарлуулах, сурагчдад сургуулийн эрүүл хоолоор хангагдах нөхцөлийг бүрдүүлэх;
- Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд амьдралын боломж муутай өрхийн сурагчдыг адил тэгш боломжоор хангана.

### **Сургуулийн хоолны зохион байгуулалт**

#### **4 дүгээр зүйл. Сургуулийн хоол**

1. Энэхүү хуульд заасан “сургуулийн хоол” гэж сургуулийн хичээлийн хуваарийн дагуу явагдах хичээлийн өдөр сургуулиас өгч буй хоолыг хэлнэ.

<sup>277</sup> <https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/111596>

2. Сургуулийн хоолонд өглөөний цай, үдээс өмнөх зууш, үдийн хоол, үдээс хойших зууш багтана.

3. Сургуулиуд нь төрөөс үзүүлэх үйлчилгээний хүрээнд бүх сурагчдыг хөнгөн хоолоор хангана. Сургуулиуд нь сурагчдад халуун хоол, эсхүл шим тэжээлтэй, илчлэг хүйтэн зуушаар хангана.

4. Сургуулиуд нь нэмэлтээр өглөөний цай, үдийн хоол, үдээс хойших зуушаар хангаж болно. Сургуулиуд нь өөрсдийн боломж бололцооныхоо хэмжээгээр сурагчдыг нэмэлт хоолоор хангана.

5. “Бага, дунд сургуулийн үдийн цайны үнэ” - сургуулиас сурагчдад санал болгож буй үдийн цайны үнийг хэлнэ. Хоолны үнийг хичээлийн жилийн эхэн бүрт Боловсролын асуудал хариуцсан сайд тогтооно (Цаашид “Сайд” гэх). 4 дэх хэсэгт заасан бусад үйлчилгээний үнийг сургууль тогтооно.

6. Сургуулийн хоолыг зохион байгуулахад Словенийн Шинжээчдийн зөвлөлөөс баталсан Ерөнхий боловсролын байгууллага дахь хооллолтод баримтлах удирдамжийг баримтлах ба дараахыг тусгана. Үүнд:

- сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой зорилго, баримтлах зарчим, боловсролын үйл ажиллагаа;
- хоол, хүнсний бүтээгдэхүүнийг сонгох, хоол төлөвлөх, хоолны хэмжээ болон бэлтгэх арга, хугацаа зэргийг тогтоосон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн яамны Нийтийн эрүүл мэндийн газраас баталсан мэргэжлийн удирдамж, аргачлалууд.

7. Сургууль нь жилийн төлөвлөгөөндөө сурагчдын эрүүл хооллолт, хоол, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагааг тусгана.

8. 2-р зүйлд заасан боловсролын байгууллагын барилга, байгууламж, орчин тойронд хоол, ундаа борлуулах автомат машин байрлуулахыг хориглоно.

9. Боловсролын байгууллагын ажилтнуудад зориулсан барилга, байгууламжид халуун ундаа борлуулах автомат машин байрлуулж болно.

## 5 дугаар зүйл. Зохион байгуулалт

1. Сургуулиуд нь хоол, хүнс худалдаж авах, боловсруулах, шаардлагатай баримт бичгийн хөтлөх, хоол, шим тэжээлтэй холбоотой боловсролын үйл ажиллагаа явуулах болон бусад ажлыг зохион байгуулна.

2. Сургууль нь сургуулийн хоолны худалдан авалт, боловсруулалт болон түгээлт зэргийг бусад боловсролын байгууллагад гэрээний үндсэн дээр шилжүүлж болно. Дээрх сургуулийн хоол, шим тэжээлтэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг гэрээгээр хүлээсэн боловсролын байгууллага нь энэхүү хуульд заасан журам, нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.

3. Онцгой тохиолдолд сургууль нь сургуулийн хоол, хүнсний худалдан авалт, боловсруулалт, түгээлт зэргийг худалдан авах ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид заасны дагуу гэрээний үндсэн дээр бусад байгууллагаар гүйцэтгүүлж болно. Сургууль нь ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг явуулахаас өмнө сургуулийн зөвлөлөөс зөвшөөрлийг авна.

4. 3 дахь хэсэгт дурдсан ажил гүйцэтгэгч нь боловсролын үйл ажиллагаатай холбоогүй хуулийн этгээд, эсхүл хувь хүн байж болно.

5. Захирал нь сургуулийн хоол, шим тэжээлийн асуудлаар санал, зөвлөмж гаргах Хоол, шим тэжээлийн бүлэг/зөвлөлийг томилж болно.

## 6 дугаар зүйл. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм

1. Сургууль нь сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой тоо, мэдээ, хоол үйлдвэрлэх, үйлчлэхэд шаардагдах хугацаа, арга зүй зэргийг Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээнд баримтлах дүрмээр нарийвчлан тогтооно.

2. Сургууль нь Хоол, шим тэжээлийн бүлэг/зөвлөлтэй тохиолдолд тэдгээрийн бүтэц, бүрэлдэхүүн, эрх үүргийн Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмээр тогтооно.

3. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг сургуулийн захирал боловсруулж, эцэг, эхийн зөвлөл, багш сурагчдаар хэлэлцүүлнэ. Дүрмийг сургуулийн хамт олон батална.

4. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм нь Сургуулийн дүрмийн нэг хэсэг байж болно.

## **7 дугаар зүйл. Сургуулийн хоолны зардал**

1. Сургуулийн сурагч, эсхүл түүний эцэг, эх сургуулийн хоолны зардлыг хариуцна.
2. Сургуулийн хоолны үнийг орон нутаг/хот, донор болон бусад эх үүсвэрээс хандив, санхүүжилт олгосон тохиолдолд бууруулж болно.

## **8 дугаар зүйл. Сургуулийн хоолны үйлчилгээнд бүртгүүлэх**

1. Эцэг, эх, асран хамгаалагч, болон хүүхдийн харгалзан дэмжигч бусад иргэд нь сургуулийн хоолны үйлчилгээ авах өргөдөл гаргана.
2. Сургуулийн хоолны үйлчилгээ хүссэн өргөдлийн загварыг Сайд батлах ба тус баримт бичгийг жилийн турш хадгална.
3. Дээрх өргөдлийг аль ч үед хүчингүй болгож болох ба өргөдлийн буцаан авах тухай хүсэлт хүлээж авсны дараах өдрөөс хүчингүйд тооцно.

## **9 дүгээр зүйл. Сургуулийн хоолноос татгалзах**

1. Сурагч нь сургуулийн хоолны үйлчилгээнээс татгалзаж болно.
2. Сурагчийн эцэг, эх нь сурагчийн өдрийн хоолыг өөрсдөө бэлтгэж өгөх тухай мэдэгдэх хуудсаар мэдээлнэ.
3. Сурагч нь сургуулийг төлөөлөн спортын тэмцээн, соёл, урлагийн арга хэмжээнд оролцох тохиолдолд тухайн өдрийн хоолыг олгохгүй.

## **10 дугаар зүйл. Үүрэг**

Сургуулийн хоолны үйлчилгээнд бүртгүүлснээр сурагч, эцэг, эх нь дараах үүргийг хүлээнэ:

- Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг дагаж мөрдөх, хүндэтгэх;
- Сургуулийн хоолны дүрэмд заасны дагуу сургуулийн хоолоор үйлчлүүлэхгүй тухайгаа цаг тухайд нь мэдээлэх.

## **11 дүгээр зүйл. Сургуулийн хоолны талаар баримтлах дүрмийг сурагч, эцэг, эхчүүдэд танилцуулах**

Сургууль нь хичээлийн жилийн эхэнд сургуулийн хоолны зохион байгуулалт, сургуулийн хоолны талаар баримтлах дүрэм, сургуулийн хоолонд олгох татаас, хөнгөлөлт зэргийн талаар Сургуулийн хоолны талаарх баримтлах дүрэмд заасан журмын дагуу танилцуулна.

## **12 дугаар зүйл. Хэрэглээгүй хоол, хүнс**

Тогтоосон хугацаанд хэрэглээгүй хоол хүнсийг сургууль нь бусад сурагчдад үнэ төлбөргүй тараах, эсхүл хүмүүнлэгийн байгууллагын жагсаалтад бүртгэлтэй хүмүүнлэгийн байгууллагад тарааж болно.

## **13 дугаар зүйл. Үдийн цайнд олгох татаас**

1. Сургуулийн үдийн цайнд олгох татаас нь үдийн цайны үнийн 2/3, болон үдийн цайны нэмэлт 1/3 татаасаас бүрдэнэ.
2. Улсын төсвөөс амьдралын боломж муутай өрхийн сурагчдад сургуулийн үдийн цайны санхүүжилтэд татаас олгоно.

## **14 дүгээр. Татаас хүлээн авагч**

1. Сургуулийн хоолны татаас авах эрх бүхий сурагч нь хууль тогтоомжоор татаас, тэтгэмж авах эрх бүхий, сургуульд тогтмол хамрагддаг, татаас авах хүсэлт гаргасан сурагч байна.
2. Дээр дурдсаныг үл харгалзан өрөнхий болон нэмэлт татаасыг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай боловсролын байгууллагын сурагчид, эсхүл гэрээр, сургуулиас гадуур боловсролын байгууллагад суралцдаг сурагч байна.
3. 1-2-т дурдсан сурагчид нь сургуульд хамрагдсан өдөр тутам болон сургуулийн хичээлийн хуваарийн дагуу зохион байгууллагдсан заавал оролцох бусад хөтөлбөрт хамрагдах тохиолдолд сургуулийн хөнгөн үдийн хоол татаас авах эрхтэй байна.

## **15 дугаар. Үдийн хоолны татаас**

1. Улсын төсвөөс сургуулийн хоолыг үнээр нь худалдан авах боломжгүй, бололцоогүй сурагчдад татаас олгоно.
2. Үдийн хоолны тэтгэмж авах орлогын хэмжээ, нөхцөл зэргийг төрөөс дэмжлэг авах асуудлыг зохицуулсан хууль журмыг баримтална.

## **17 дугаар зүйл. Сургуулийн хоол тэжээлийн баримтжуулалт**

1. Сургууль нь сургуулийн хоолны үйлчилгээ авагч сурагчдын дараах мэдээллийг бүртгэнэ. /2-4-р заалтад Сурагчийн хувийн мэдээллийг ашиглахтай холбоотой болон тэтгэмж, татаастай холбоотой мэдээллийг тусгасан/
5. Сургууль нь сургуулийн хоолтой холбоотой тоо, мэдээг холбогдох яаманд жилд нэг удаа хүргүүлнэ.
6. Энэхүү заалтад заасан мэдээллийг хувийн нууцын тухай хууль тогтоомжийн дагуу цуглуулж, ашиглаж, хадгална. Яам нь энэхүү хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зөвхөн нийт дүн, мэдээ, статистикийг ашиглана.
7. Статистик дүн мэдээнд сургач, эцэг, эхийн талаарх хувийн мэдээллийг (овог, нэр) ил болгохгүйгээр ашиглаж болно.
8. Холбогдох статистик тоо мэдээг 5 жил хадгална.

## **18 дугаар зүйл. Татаас олгох**

Сургууль нь татаас авахтай холбоотой өмнөх сарын тоо мэдээг дараа сар бүрийн 10-ны дотор Яаманд хүргүүлнэ. Сургуулийн хоол, үдийн цайны татаастай холбоотой дараах мэдээллийн нийт дүнг:

- Бүртгүүлсэн сурагчдын тоо;
- Хөнгөлөлттэй үнээр олгосон хоолны тоо;
- Татгалзсан сурагчдын тоо;
- Өвчтэй, эсхүл бусад шалтгаанаар хоолны үйлчилгээнд хамрагдаагүй сурагчдын тоо.

## **Хяналт үнэлгээ**

### **19 дүгээр зүйл. Дотоод мониторинг**

Сургуулийн хичээлийн жилийн хугацаанд сургач, эцэг, эхчүүдээс сургуулийн хоолны чанар, хоол, шим тэжээлийн боловсролын хүрээнд хийгдэж буй арга хэмжээ, үйл ажиллагааны сэтгэл ханамжийн судалгаа явуулна.

### **20 дугаар зүйл. Мэргэжлийн хяналт**

Сургуулийн хоолыг 4.6-д заасан мэргэжлийн удирдамжуудад нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн хяналт тавьж, сургуулиудад зохих зөвлөмж гаргана. Мэргэжлийн хяналтыг нийтийн эрүүл мэндийн хяналтыг хэрэгжүүлэгч төрийн байгууллагаас төлөвлөж, хэрэгжүүлнэ. Тодорхой боловсролын байгууллагад мэргэжлийн хяналт, шалгалтыг Боловсрол, шинжлэх ухаан, спортын яамны Боловсрол, спортын хяналтын газрын санаачилгаар явуулж болно. (Inspectorate of the Republic of Slovenia for Education and Sport)

### **21 дүгээр зүйл. Дотоод хяналт**

Захирал нь ажил гүйцэтгэгч, эсхүл бусад боловсролын байгууллагын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавина. Захирал нь илрүүлсэн зөрчлийг арилгуулах шаардлагыг ажил гүйцэтгэгчид бичгээр гаргана. Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгч шаардлагыг биелүүлэгүй бол сургууль нь гэрээгээ цуцлах эрхтэй байна.

### **22 дугаар зүйл. Гадаад/Хөндлөнгийн хяналт**

Боловсрол, спортын хяналтын газар сургуулийн сургуулийн хоолны үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой холбоотой асуудлаар хяналт тавьж, бусад эрх бүхий хяналтын байгууллага нь өөрсдийн эрх мэдлийн хүрээнд даарах хяналт тавина.

- Энэхүү хуульд заасан хөрөнгийн зарцуулалт зорилгын дагуу зарцуулагдсан эсэхэд төсвийн хяналт,

- Хувийн мэдээллийн хамгаалалтын асуудлаар хуульд заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий мэдээллийн ажилтан.

## **Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

### **23 дугаар зүйл. Торгууль**

1. Сургуулийн байцаагч (School Inspector) нь 1000-2000 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуульд ногдуулна.

- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зуршил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй;
- 4.5-д заасан хоолны зардлыг харгалзан үзээгүй;
- 8.8-9-т заасныг зөрчин хүнс, ундааны автомат машин суурилуулсан;
- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;
- Сургуулийн хоолны шим, тэжээлийн баримтжуулалт үйлдээгүй;
- Төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч мэдээлэл бүрдүүлсэн.

2. Сургуулийн байцаагч нь 500-1000 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн этгээдэд ногдуулна.

- Сургуулийн хоолны үйлчилгээ үзүүлдэггүй, сургуулийн жилийн төлөвлөгөөндөө хоолны зөв дадал зуршил, шим тэжээлийн боловсролтой холбоотой үйл ажиллагаа тусгаагүй;
- 4.5-д заасан хоолны зардлыг харгалзан үзээгүй;
- 8.8-9-т заасныг зөрчин хүнс, ундааны автомат машин суурилуулахыг зөвшөөрсөн;
- Ажил гүйцэтгэгчтэй холбогдох зөвшөөрөл авалгүй гэрээ байгуулсан;
- Сургуулийн хоолны үйлчилгээ авагч сурагчдын жагсаалтыг гаргаагүй;
- Төрөөс хоолны татаас, тэтгэмж авахад хуурамч баримт бүрдүүлсэн.

3. Сургуулийн байцаагч нь 100-200 хүртэлх европийн хэмжээтэй торгуулийг дараах хөнгөн гэмт хэрэг /misdemeanour/ үйлдсэн сургуулийн ажилтанд ногдуулна.

- Сургуулийн хоолны дүрэмд санал өгөөгүй;
- Дотоод мониторинг явуулаагүй;
- Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагааг хянаагүй, зөрчил илрүүлсэн тохиолдолд арилгуулах арга хэмжээ аваагүй, сануулга өгөөгүй.

24 дүгээр зүйлд сургуулийн үдийн цайны үнийн талаар шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх талаар, 25 дугаар зүйлд Үдийн цайны татаас олгох шалгуур, өрхийн орлогын хэмжээг, 26 дугаар зүйлд Үдийн хоолны татаас олгох шалгуур, өрхийн орлогын хэмжээг тус тус нарийвчлан заасан байна.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Судалгааны тайлан:

- Schools as a System to Improve Nutrition: A new statement for school-based food and nutrition interventions, United Nations System Standing Committee on Nutrition, 2017
- School meals in Europe, Report by the Polish Eurydice Unit, 2016
- Global School Feeding Sourcebook, Lessons from 14 countries, Imperial College Press, 2016
- Country profiles on across the EU28 national school food policies plus Norway and Switzerland, European Commission, 2015
- Policies and Guidelines Shaping the School Food Environment, A Review of the Literature, Nutrition Resource Centre, 2015
- The State of School Feeding Worldwide 2013, World Food Programme
- School Feeding in APEC Economies, APEC Subcommittee on Standards and Conformance, 2012

Япон

- <http://www.mext.go.jp/en/>
- <http://school-lunch-support.jp/en/act/>
- <http://school-lunch-support.jp/en/implementation-standards/>
- <http://www.mext.go.jp/english/museumofmext/>; <http://www.mext.go.jp/joho-hiroba/rooms/kyouiku.htm>
- <https://pdfs.semanticscholar.org/010c/4141daaa8ac20a0abde52591b78cf75199ac.pdf>
- <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303SLP.pdf>
- The Japanese School Lunch and Its Contribution to Health, Nutrition today, December 2015
- [https://www.japanfs.org/en/news/archives/news\\_id035892.html](https://www.japanfs.org/en/news/archives/news_id035892.html)

БНХАУ

- [https://apec.org/-/..../APEC/..../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012\\_scs](https://apec.org/-/..../APEC/..../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs)

БНСУ

- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=29851&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=29851&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=31660&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=31660&lang=ENG)
- [https://apec.org/-/..../APEC/..../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012\\_scs](https://apec.org/-/..../APEC/..../Research-School-Feeding-in-APEC-Economies/2012_scs)
- <http://www.koreaherald.com/view.php?ud=20160824000869>
- <http://www.loc.gov/law/foreign-news/article/south-korea-coffee-banned-in-schools/>

ОХУ

- Федеральный закон от 29.12.2012 № 273-ФЗ «Об образовании в Российской Федерации».
- [https://www.menobr.ru/article/65396-qqq-18-m1-organizatsiya-pitaniya-v-shkole?from=PW\\_Timer\\_other&ustp=W](https://www.menobr.ru/article/65396-qqq-18-m1-organizatsiya-pitaniya-v-shkole?from=PW_Timer_other&ustp=W)
- <https://www.audit-it.ru/articles/account/otrasl/a100/916425.html>
- <http://www.kremlinrus.ru/news/165/77186/>
- <http://39.rosпотребнадзор.ru/content/organizaciya-pitaniya-v-shkole>

Словени Улс

- <https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/111596>
- <http://www.nycfoodpolicy.org/slovenia-school-nutrition-law/>

